

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2013. 10 сар. №20 (054)

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)


“Сургамжтай” төсөв

Хятадын шинэ эдийн засаг

Оюутолгой ба шалгалт



**ҮНДЭСНИЙ ҮЙЛДВӨРЛЭЛ  
ХӨГЖИЖ, ЭДИЙН ЗАСАГ ӨСНӨ**



# Retina дэлгэцтэй MacBook Pro

Зөөврийн компьютерийн шинэ үе

Гайхалтай хурц бөгөөд амьд мэдрэмж өгөх дэлгэц, илүү боловсронгуй all-flash архитектур буюу санах ойг маш нимгэн бөгөөд хөнгөхөн загвартай MacBook Pro-д суулган өгч дээд хүчин чадлаар нь ажиллуулах боломжтой болгожээ.



Индонезийн **PT UNITED TRACTORS PANDU ENGINEERING** буюу **PATRIA Компани** нь 1983 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд өдгөө хүнд даацын тоног төхөөрөмжийн ачаа тээвэрлэх эд ангийн дэлхийд тэргүүлэх үйлдвэрүүдийн нэг болтлоо өргөжиж хэрэглэгчдийнхээ хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн, дэвшилтэт технологийн бүтээгдэхүүнүүдийг дэлхийн зах зээлд амжилттай нийлүүлж байна.



## ТРАНСВЕСТ МОНГОЛИА ХХК НЬ **PATRIA** КОМПАНИЙ ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮДИЙГ МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛД НИЙЛҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ

### ► БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



Төрөл бүрийн тэвш, чиргүүл, ус болон шатахуун тээвэрлэлтийн ёмкость, тосолгооны машины тусгай ёмкость, экскаваторын шанага, бульдозерын хутга г.м

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:  
ОРЧУУЛАГЧ:

Теренс Эдвардс  
Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох  
Э.Зоригт  
Х.Хулан

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

Вэб мастер:

Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав /9409-2904/  
Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ

РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг. VI хороо,  
Их сургуулийн гудамж. AV center. 503 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

[info@mongolianeconomy.mn](mailto:info@mongolianeconomy.mn)

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

## IV УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

### РЕДАКЦИД ЗАХИАЛБАЛ ХҮРГЭЛТ ҮНЭГҮЙ

УТАС:70115476

ЦАХИМ СЭТГҮҮЛИЙГ  
<http://mongolianeconomy.imedia.mn/>  
хаягаар захиална уу




CPU: Intel i5-3337U  
RAM: 4GB DDR3  
HDD: 128GB SSD  
Display: 11.6 Full HD  
          dual screens Touch  
OS: Win 8 Pro  
Battery: 6 Cell




**2'787'000₮**


ХОС ДЭЛГЭЦ ГОРИМ



ТОЛИН ГОРИМ



ТАБЛЕТ ГОРИМ



НӨҮТБҮҮК ГОРИМ

# ASUS TAICHI 21 НӨҮТБҮҮК ТАБЛЕТИЙН УХААЛАГ НЭГДЭЛ

Таны хүсэл, хэрэгцээг нэг дор цогцлоосон таблет, нөүтбүүкийн нэгдэл, хос дэлгэцээр ажилладаг ASUS TAICHI ультрабүүкийг танилцуулж байна. Ердөө ганцхан товчлуур дээр дараад нөүтбүүк, таблет, толин, хос дэлгэц гэсэн 4 горимд хялбархан шилжин таны ажлыг хөнгөвчилнө.

- Интелийн 3 дахь үеийн эрчим хүч бага зарцуулдаг хүчирхэг процессор
- Мэдээллийг 10 дахин өндөр хурдаар дамжуулах USB 3.0 холболт
- Бат бөх, хөнгөн SSD хард диск
- Ердөө 1.25 кг жинтэй
- Тасралтгүй 5 цаг ажиллах батерей



**40<sup>th</sup>**  
**ANNIVERSARY**  
**SHARP**  
**DOCUMENT BUSINESS**  
**1972 - 2012**



## ТАСРАЛТГҮЙ ӨСӨХ БИЗНЕСИЙН ХУРД

Дэлхий даяар хурдан, бүтээмжтэй, ухаалаг ажиллагааг түгээх хувилагчийн борлуулалт 1972 онд эхэлснээс хойш тогтвортой өссөөр байна.



**PC mall**



7011-3535



Visit us:  
[www.pc-mall.mn](http://www.pc-mall.mn)



Join us on Facebook  
<http://www.facebook.com/PCmallOfficial>

Сүхбаатар дүүрэг, Их Сургуулийн гудамж 31/1, PC mall  
 Саммит Компьютер Технологи ХХК, Улаанбаатар-14193, Монгол улс

## ЭДИЙН ЗАСАГ

**10** Тэргүүн зорилт**12** Хямралын дараах мөнгөний бодлого**15** “Сургамжтай” төсөв**18** Хөрөнгө оруулалтын сангийн эхлэл тавигдлаа**20** Хаалттай улсын нээлттэй хаалга**22** Хятадын шинэ эдийн засаг**24** Босго давахын зовлон

## УУЛ УУРХАЙ

**28** Оюутолгой ба шалгалт**31** Хүлээлт**33** Хөгжлийн унаа хөдөөг зорьжээ

## БИЗНЕС

**34** Бусдаас ялгар**36** Эдийн засгийн хөгжлийн төлөө эрүүл мэндийг золиослох ёсгүй**46** Түр зуурын давуу тал

МОНГОЛД

**ТАТВАР**

Татварын багц хуулийн хүрээнд ирэх онд 17 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой иргэдийн төлөх татварын нэр төрөл нэмэгдэхээр болжээ. Тухайлбал, “Хотын татвар” шинээр бий болж Улаанбаатарт ажиллаж, амьдарч байгаа иргэд, оюутнууд, үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж бүрээс энэ төрлийн татвар авах хуулийн төсөл бэлэн болсон байгаа аж. Мөн “Хотын татвар”-т хамаарах “Үйлчилгээний татвар”-ыг аймаг, хотод үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний газраар үйлчилүүлсэн иргэд төлдөг



болох юм. Энэ нь иргэд хотын аль нэг ресторан, дэлгүүр, хоолны газраар үйлчлүүлэх бүртээ татвар төлнө гэсэн үг аж.

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

Герман-Монголын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” чуулга уулзалт энэ сарын 23-24-нд “Блю Скай” зочид буудалд болно. Эдийн засаг хөгжлийн яам, БОНХЯ, Санхүүгийн зохицуулах хороо, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс, баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга /ЭТИС/ хөтөлбөр хамтран зохион байгуулах юм. Чуулган “Компанийн нийгмийн хариуцлага” болон “Уул уурхайн салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд” сэдвийн дор болно. Дээрх хоёр үндсэн сэдвээр Герман, Монголын эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүд илтгэл тавьж, үндэсний хэмжээнд хэлэлцүүлэг өрнүүлэх аж.

**ХУУЛЬ**




УИХ-ын ээлжит бус чуулганаар “Алтны худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх тухай” хуулийн төслийг хэлэлцүүлж байгаа. Одоо мөрдөгдөж буй хуулиар олборлосон алтаа Монголбанк, эсхүл Монголын арилжааны банкинд тушаасан тохиолдолд алтны тухайд суурь нөөц ашигласны төлбөр буюу роялти таван хувьтай, өсөн нэмэгдэх роялти мөн хэмжээний хувьтай байгаа. Хэрвээ шинэ хууль батлагдаж, алт олборлогчид Монголбанк, арилжааны банкинд алтаа тушаавал нөөц ашигласны төлбөрийг 2.5 хувиар тооцож, өсөн

нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийг “0” хувьтай байхаар заажээ. Энэ нь гадагшаа урсдаг алтны нөөцийг Монголбанкинд аргамжиж, валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийн чадавхыг сайжруулах боломж юм.

**ИНФЛЯЦИ**

Өнөөдрийн байдлаар жилийн инфляцийн түвшин 9.9 хувьтай байна. Нийт инфляцийн өсөлтийн 40 орчим хувь нь бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнтэй холбоотой байгаа талаар Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаанд дурджээ. Одоогоор хүнсний бараа бүтээгдэхүүний 60 орчим хувьд нь үнийн өөрчлөлт орсон байна. Олон жилийн дунджаас харахад оны эцсээр өргөн хэрэглээний барааны үнэ өсдөг хандлага бий. Тиймээс оны төгсгөлд инфляци хоёр оронтой тоонд орж магадгүй гэх хүлээлт байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн есдүгээр сарын байдлаар (сая ам.доллар)



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо (жил бүрийн есдүгээр сарын байдлаар)



## ДЭЛХИЙ ДАХИНД

### АНУ



АНУ-ыг өрийн дарамтад орохоос урьдчилан сэргийлэх гэсэн улс төрийн оролдлого бүтэлгүйтсээр. Тус улсын дээд танхимын удирдагчид өрийн дээд хэмжээг нэмэгдүүлж, Засгийн газрын хэсэгчилсэн байдлаар зогсоосон үйл ажиллагааг сэргээхийн тулд өдөр, шөнөгүй ажиллаж буй. Конгрессийн үймээний хажуугаар тус улсын зээлжих зэрэглэлийг бууруулах магадлалтай гэдгийг үнэлгээний компани сануулжээ. АНУ-ын өрийн дээд хэмжээ болох 16.7 их наяд ам.долларыг тун ойрын үед нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд эс бөгөөс эрсдэлд орох аж.

### ЕВРОБҮС



Евробүсийн үйлдвэрлэлийн гарц өнгөрсөн наймдугаар сард сүүлийн хоёр жилд байгаагүйгээр огцом өсчээ. Уг бүсийн 17 орны үйлдвэрлэлийн гарц нэг хувиар өссөн нь шинжээчдийн таамаглаж байснаас ялимгүй дээгүүр үзүүлэлт аж. Германы үйлдвэрлэлийн гарц 1.8 хувиар, Францынх 0.2

хувиар тус тус өссөн бол Италийн гарц 0.3 хувиар буурчээ.

### БНХАУ

БНХАУ-ын хувьцааны



үнэ сүүлийн гурван долоо хоногт ихээр буурах болов. Энэ нь Шанхай хотын чөлөөт худалдааны бүсэд үнэлгээ хэтэрхий их байснаас уг бүстэй холбоотой холдинг болон компаниудын тоог “JPMorgan Chase & Co” санхүүгийн үйлчилгээний компани цөөлөх болсонтой холбоотой аж. The Shanghai Composite Index (SHCOMP) индекс 1.6 хувиар буурч, 2,196.94 болсон нь өнгөрсөн сарын 26-наас хойшхи хамгийн том алдагдалд тооцогдож байна.

### ОХУ

ОХУ-ын Төвбанк бодлогын хүүний ханшаа удаан хугацаанд 5.5 хувь дээр байлгасаар иржээ. Энэ нь сүүлийн 11 сарын туршид огт өөрчлөгдөөгүй ханш болохыг “Ройтерс” агентлаг мэдээлсэн байна. Тус улсын эдийн засгийн өсөлт тааруухан байгаагаас үл хамааран айл өрх болон бизнес эрхлэгчдэд зориулан инфляцийг бууруулах арга хэмжээг авахаар зэхэж байгаа аж. Энэ сарын 7-ны байдлаар инфляцийн түвшин зургаан хувьтай байсан бөгөөд энэ онд 5-6 хувийн хооронд хэлбэлзэх талаар тус банкнаас мэдэгджээ. Энэ оны сүүл



гэхэд таван хувь болгон буулгах зорилттой байгаа


бөгөөд ирэх онд инфляци буурна гэсэн хүлээлттэй байна.

### ЯПОН



Японы Ерөнхий сайд Шинзо Абэ энэ сарын дундуур Парламентад хандаж хэлсэн үгэндээ эдийн засгаа удаан хугацааны дефляциас гаргахын тулд реформ хийж, эдийн засгийн арга хэмжээ авахаа амлажээ. Үүний дүнд өрхийн зарлага, хөрөнгө оруулалтыг дэмжих боломжтой болох аж. Тэрбээр хэрэгжүүлж буй бодлогынхоо хүрээнд үндэсний аюулгүй байдлыг чангатгах, мөн дэлхий дахинд энхийг сахиулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох зэрэг төлөвлөгөөг санал болгохоор зэхэж буй.

## А.АМАРСАЙХАНЫ БУЛАН





Фотог Б.Бямба-Очир

## МӨНГӨНИЙ БОДЛОГО

“Ирэх оны мөнгөний бодлогын хүрээнд инфляцийн түвшинг найман хувиас хэтрүүлэхгүй”

# ТЭРГҮҮН ЗОРИЛТ

### Б.АЛТАЙ

Ирэх оны мөнгөний бодлогыг УИХ-аар хэлэлцэж байна. Мөнгөний бодлого дунд болон урт хугацааны эдийн засгийн хөгжлийг онилж байх учиртай. Тиймээс ирэх онд хэрэгжих мөнгөний бодлогын “богц”-ыг урьтан задалъя. Хямралын “шок”-оо дөнгөж гэтэлж буй эдийн засаг ямар мөнгөний бодлогоор замнах вэ. Төвбанкны ерөнхийлөгчийн зөвлөх С.Болд “Ирэх оны мөнгөний бодлого 2013 оны бодлогыг үргэлжлүүлнэ. Санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, хадгалах, эдийн засгийн бодит салбарыг мөнгөний бодлоготой уялдуулж дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. Мөнгөний бодлогоор дамжуулж эдийн засгийн дархлааг сайжруулахаас гадна макро

эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ” хэмээсэн.

Ирэх оны мөнгөний бодлогын хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах зорилгоор инфляцийн түвшинг найман хувьд барих аж. Түүнчлэн гадаад орчноос дотоодын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нэг салбараас хэт хамаарах хамаарлыг багасгах, эдийн засгийн урт хугацааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, дархлааг сайжруулах нь ирэх оны мөнгөний бодлогын үндсэн зорилтуудын нэг юм. Нөгөөтэйгүүр дотоодын үйлдвэрлэл, хуримтлалд суурилсан, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангахын тулд богино хугацаанд экспортыг дэмжих, гадаад валютын урсгалыг сайжруулах үүргийг Төвбанк бодлогоороо хүлээж

байна.

Харин дунд болон урт хугацаанд импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх шаардлага гарч байгаа нь мөнгөний бодлогын сорилт юм. Дээрх амлалт нь Монголбанкны үүргээс ахадсан болохыг зарим эдийн засагчид хэлдэг. Төвбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн онолын тэнхмийн эрхлэгч Б.Алтанцэцэг “Мөнгөний бодлого макро эдийн засгийн хүчтэй хэрэгсэл. Мөн уян хатан шинжтэй. Уг бодлогоор дамжуулан богино хугацаанд эдийн засагт тодорхой хэмжээний өөрчлөлт гаргах боломжтой” хэмээн мөнгөний бодлогын мөн чанарыг онцлов. ▶

## Зүгээр суухад амжилт ирэхгүй

Ипотекийн зээл 2014 онд Төвбанкны дэмжлэгтэйгээр үргэлжлэн хэрэгжих учиртай. Ингэснээр үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл хөгжих, Нийгмийн даатгалын сан дахин хөрөнгөжих боломжийг олгох юм. Тус сангийн орлого нэмэгдэхийн хэрээр тогтолцоог хэрэгжүүлэгч талууд санхүүгийн хувьд чадавхжих аж. Ингэснээр цаашдаа Монголбанкны оролцоогүйгээр тогтвортой хэрэгжих боломж бүрдэнэ хэмээн мөнгөний бодлогод дурджээ. С.Болд “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгосноор иргэдийн орлого хэрэглээнээс хуримтлал руу шилжих давуу талтай” хэмээв.

Гаднын хөрөнгө оруулалт буурсан /47 хувиар буюу 1.6 тэрбум ам.доллараар/, эдийн засгийн өсөлт саарсан, Хятадын амжилт уруудсан, уул уурхайн гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ бараг 50 хувь “газардсан”, төлбөрийн нийт тэнцэл 1.4 тэрбум ам.долларын алдагдал хүлээсэн таагүй нөхцөлд ирэх оны мөнгөний бодлого хэрэгжинэ. Нөхцөл байдал урьдынхаас сайжирсан ч гэсэн эдийн засаг эмзэг хэвээр. Монголбанк дээр тэмдэглэсэн зорилтод хүрэхийн тулд мөнгөний уламжлалт ба уламжлалт бус бодлогын арга хэрэгслийг хослуулан хэрэгжүүлэх аж. Уг мөнгөний бодлогоор дотоодын үнийн тогтвортой байдлыг хангаж, иргэдийн бодит орлогыг хамгаална хэмээн үзэж байна.

Мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр” ирэх онд дахин үргэлжлэх аж. Гэхдээ хөтөлбөрт зааснаар дунд хугацаанд хувийн хэвшилдээ тулгуурласан зөв тогтолцоог зах зээлд бий болгоод Монголбанк хөтөлбөрөөс гарах болзолтой. Тиймээс цаашдаа Засгийн газар Монголбанкинд бус хувийн хэвшилд тулгуурлаж, эдийн засгаа амжилттай удирдах, улсаа хөгжүүлэх шаардлага үүсч байгаа юм.

Гадаад худалдааны алдагдлаа

хөрөнгө оруулалтаар нөхөж ирсэн манай улсын хувьд ирэх онд хатуу мөнгөний бодлого илүү зохимжтой болохыг Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурийн төлөөлөгчийн газрын ахлах эдийн засагч Яан Хансэн зөвлөсөн. Азийн хөгжлийн банкнаас манай улсыг одоо баримталж буй эдийн засгийн тэлэх бодлогоос түр татгалзах хэрэгтэйг санууллаа. Монголбанк энэ онд эдийн засагт хангалттай хэмжээний мөнгө нийлүүлсэн гэж тэд үзэж байна. Дэлхийн банк ч мөн адил дээрх саналыг дэвшүүлээд байгаа. Гэсэн ч Монголбанкны мөнгөний бодлого эсрэг “мордох” бололтой.

“Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн”-гийн захирал Б.Түвшинтөгс “Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд Төвбанкнаас Засгийн газарт олгож буй зээл огцом өссөн. Өөрөөр хэлбэл, эдийн засагт маш их хэмжээгээр мөнгө нийлүүлж байгаа нь ам.доллартай харьцах төгрөгийн ханшийн өсөлтөд нөлөөлсөн. Эдийн засагт эргэлдэж буй мөнгөний хэмжээ ихсэх тусам төгрөгийн үнэ цэнэ алгуур бууж байдаг” гэв.

“Мөнгө хэнд байна, түүнд эрх мэдэл бий”. Үүнтэй адил Монголбанк унасан эдийн засгаа татаж босгосныг хүлээн зөвшөөрөх хүн цөөнгүй. Хэрвээ Төвбанкнаас 2.8 их наяд төгрөгийг эдийн засагт хийж, мөнгөжүүлээгүй бол, Үнэ тогтворуулах хөтөлбөр зарлаагүй бол валютын ханшийн савлагаанаас үүдэн шатахууны үнэ 50 хувь нэмэгдэх байсныг Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал хэллээ. Банкны зээл хумигдчихсан, валют эрс багасчихсан, нүүрсний экспорт 50 хувиар багассан гээд эдийн засгийн хувь заяа хаашаа ч эргэж магадгүй хүнд үед зах зээл дэх нийт мөнгөний хэмжээг 13 хувиар нэмж ДНБ-ийг 11 хувь өсгөж чадсан нь үнэн. Өөрөөр хэлбэл, 11 хувийн өсөлт их үнээр олдсон гэдгийг санах нь зүйтэй байх.

Мөнгөний бодлогын төсөлд өгүүлснээр 2015-2016 оны инфляцийн зорилт долоон хувиас хэтрэхгүй байхаар зурагласан. Инфляци “мөрөөдсөн” ёсоор тогтвортой байхаас та бидний орлогын тодорхой хэсэг хуримтлал

болж чадах эсэх хамаарна. Харин эдийн засагт итгэл эвдэх төгрөгийн гадаад валюттай харьцах ханш зах зээлийн жамаа дагах нь. Монголбанкны зүгээс эдийн засгийнхаа суурь нөхцөлтэй уялдаж, ирэх онд ханшийн уян хатан тогтолцоог баримтлах аж. Энэ тохиолдолд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, уул уурхайн бүтээгдэхүүний үнийг “тахин шүтэх”, алтны тушаалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Мөнгөний бодлогод “Ханшийн өнөөгийн төлөв байдал нь импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг урамшуулах, гадаад худалдааны алдагдлыг бууруулах, эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах таатай орчинг бүрдүүлж байна” хэмээн өгүүлжээ.

## Гарааны жил

“Хараат бус төв банкны тогтолцоонд мөнгөний бодлогын гол зорилго, эрмэлзэл нь инфляцийг удирдах буюу инфляцийг бага түвшинд байлгах” гэж судлаач Б.Оюунбилэгт өгүүлсэн. Тиймээс ирэх оны мөнгөний бодлогын тэргүүн зорилт нь инфляцийг тогтворжуулахад чиглэж буй. Энгийнээр хэлэхэд, эдийн засагт дахин боломж олгохуйц мөнгөний бодлого ирэх онд хэрэгжих төлөвтэй. Ирэх оны мөнгөний бодлогод ДНБ-ий өсөлтийг 14.4 хувиар тооцсон байна.

Төвбанкны одоогийн явуулж буй мөнгөний бодлогын талаар Б.Алтанцэцэг багш “Монголбанкнаас хэрэгжүүлж буй өнөөгийн олон талт бодлогын үр дүн эрсдэлтэй харагдаж байна. Уг нь инфляци болон санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад гол анхаарлаа хандуулах учиртай. Хэрэв Монголбанкинд итгэх иргэдийн итгэл алдарвал мөнгөний бодлогоор инфляцийг удирдахад амаргүй болж, мөнгөний бодлогын үр нөлөө сулрах аюултай” хэмээн анхаарууллаа. 2014 оныг эерэг байдлаар харвал Монгол Улсын хувьд дотоодын үйлдвэрлэлээ мөнгөний бодлогоор дэмжсэн гарааны жил. ■

## ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ХЯМРАЛЫН ДАРААХ  
МӨНГӨНИЙ БОДЛОГО

Р.ГАНТУЛГА

Дэлхий дахинд санхүүгийн хямрал днүүлэхээс өмнө Төвбанкууд амар жимэр амьдарч байсан бөгөөд эрхэм зорилго нь ч тодорхой байв. Үүнд инфляцийн түвшинг доогуур байлгаж, тогтвортой хадгалахын тулд огцом өсөлт, бууралтыг хянаж, хязгаарлах. Ингэхдээ богино хугацаат бодлогын хүүний ханшийг зээл авах боломжгүй болтол аажмаар өсгөх (инфляцийг зогсоох зорилгоор) эсхүл зээл авах боломжтой болтол буулгах (эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор) зэргээр тухайн үедээ үр дүнтэй байсан арга хэрэгслүүдийг ашигладаг байжээ. Энэ техникийг уран аргаар ашиглаж байсан нь хүмүүсийг удаан хугацаанд амар, жимэр байлгаж чадсан юм. Гэхдээ эдийн засагчид дэлхийн эдийн засгийн өсөлт 1980 оны дунд үеэс удааширч эхэлсэн (Great Moderation)-ийг албан ёсоор зарлах үеийг хүртэл. Тухайн үедээ уг удаашралт тур зуурын чанартай байсан боловч нөхцөл байдал эсрэгээр эргэж, гэнэтийн уналтад орсон байна. Энэ нь Төвбанкныхны хадгалж байсан мэдээлэл төдийгүй тэдгээрийн эдийн засгийн өсөлтийг дэмждэг байсан арга барилыг нь хүртэл үнэгүйдүүлэх болов. Үүнтэй холбоотойгоор тухайн үеийн мөнгөний бодлогод урьд, хожид байгаагүй томоохон эргэлт гарах үндэс тавигджээ.

Өр, зээлийн хэт их дарамтаас үүдэн 2008 оны наймдугаар сард дэлхийн эдийн засаг хямралд өртсөн



нь эрэлтийг ихээр нэмэгдүүлэх болсон. Үүний эсрэг хөгжингүй орнуудын Төвбанкууд бодлогын хүүгээ огцом бууруулсан байна. 2009 оны эхэн үе гэхэд олон Төвбанк бодлогын хүүний ханшаа ихээр бууруулсан нь эдийн засагчдын нэрлэдэг “Тэг хувийн бодлогын хүү” (zero lower bound) рүү маш ойртуулсан хэрэг болжээ. Гэвч эдийн засгийн өсөлтийг тодорхойлоход хүндрэлтэй хэвээр л байв. Хүүний ханшийг тэгээс доош буулгах нь техникийн хувьд боломжтой ч өгөөжөө хэр сайн өгөх нь тодорхойгүй байлаа. Нөгөө талаас энэ нь хадгаламж эзэмшигчдийг банкнаас мөнгөө татаж, бэлэн мөнгө хэлбэрээр хадгалах ашиг, сонирхол руу хөтлөх муу үр дагавартай байв. Хөгжингүй орнуудын Төвбанкууд ажилгүйдэл ихэсч, үйлдвэрлэлийн гарц муудах болсон зэрэг хүндхэн асуудалтай тулгарч, мөнгөний бодлогын гол суурь

болж байсан дээрх хэрэгслүүдэд дэмжлэг болж чадах эсэх нь нэгэнт баталгаагүй болжээ.

Төвбанкууд бүгдээрээ дээрх сорилтод бэлэн биш байсан уу гэвэл үгүй юм. Япон улсад 90-ээд онд үл хөдлөх хөрөнгийн үнэ огцом буурсны дараа эдийн засаг нь уналтад орж эхэлсэн байна. Эдийн засгийн өсөлт нь суларч, дефляци үүссэн учраас Төвбанкнаас нь бодлогын хүүний ханшаа тэг хувьтай тун ойрхон түвшинд буулгажээ. Ийнхүү мөнгөний шинэ бодлогыг анх санаачилж, удаа дараагийн туршилт явуулж байсан удаатай. Гэхдээ тус банкны гүйцэтгэл тааруухан үзүүлэлттэй байсан гэх шуугиан тухайн үед чих дэлсэж байлаа.

Мөнгөний шинэ бодлогыг хоёр том бүлэгт хувааж авч үздэг байна. Нэгдүгээрт, хөрөнгө худалдан авах (assets purchases) болон ▶

► хоёрдугаарт, цаашдын удирдамж гаргах (forward guidance). Эхнийх нь Төвбанкуудын хувьд байдаг л арга хэмжээ. Тухайлбал, АНУ-ын Холбооны нөөцийн банк мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, богино хугацаат хүүний ханшийг бууруулах зорилгоор Засгийн газраас гаргасан “Treasury bills” болон бусад богино хугацаат бондыг удаан хугацаанд худалдан авч байв. Харин тус банк бодлогын хүүний ханшаа тэг хувьтай ойртуулах үедээ урт хугацаанд үргэлжилсэн зээлийн зардлаа бууруулах зорилгоор арван жилийн хугацаат Засгийн газрын бонд болон моргейжийг дэмжсэн урт хугацаат бондыг худалдан авч эхэлжээ. /Хүснэгт 1-ийг харна уу/



Хөрөнгө худалдан авах зорилгоор мөнгөн тэмдэгт шинээр үйлдвэрлэж, мөнгөний зах зээлд нийлүүлэхийг “quantitative easing” (QE) гэдэг. Төвбанкууд өөрсдийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө худалдан авах төлөвлөгөө гаргаж, албан ёсоор олон нийтэд зарладаг. Японы Төвбанк анх 2001 онд QE хэрэгжүүлэхийг оролдож байв. Тухайн үед өөрийн нөөцийн хэмжээг таван их наяд иенд хүргэх зорилгоор сар бүр 400 тэрбум иенийн үнэлгээтэй Засгийн газрын бондыг худалдан авахаа амлаж байжээ. Харин 2008 оны санхүүгийн хямрал болсноос хойш АНУ, Англи болон Японы Төвбанк санхүүгийн хөрөнгийн янз бүрийн бонд, үнэт цаасыг худалдан авч, QE-г жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж эхэлсэн байна. /Хүснэгт 2-ыг харна уу/



Эдийн засагчдын үзэж буйгаар QE-г хэрэгжүүлэх цөөхөн арга зам байдаг аж. Төвбанкныхны хувьд “Үнэт цаасны багцыг тэнцвэржүүлэх үр нөлөө” (portfolio-balance effect)-ний ач холбогдлыг чухалчлан үздэг. Төвбанкууд шинээр гаргасан мөнгөөрөө хөрөнгө оруулагчдаас бонд худалдан авахдаа эрсдэл, хугацаа нь харилцан адилгүй янз бүрийн хөрөнгийг худалдан авдаг байна. Энэ нь үнэт цаасны багцаа улам сайжруулах зорилготой бөгөөд үүний тулд үнэт цааснаас олсон ашиг, орлого (proceeds)-ыг ашигладаг аж. Үүнийг хийхдээ хөрөнгийн үнийг огцом нэмэгдүүлж, харин бодлогын хүүний ханшийг бууруулдаг байна (Бондын эрэлтийг нэмэгдүүлснээр доогуур ханшаар борлуулах боломж бүрддэг). Үүний дүнд хямдхан зээл авах боломж бий болж, улмаар бизнес эрхлэгчид болон өрхүүдийн зүгээс хийх хөрөнгө оруулалтад дэмжлэг болдог.

QE нь санхүүгийн үр нөлөөгөөр дамжин эдийн засгийг дэмжих боломжтой. Бодлогын хүүний ханш буурснаар Засгийн газрын зээлийн зардал багасч, цаашилбал татвар хөнгөлөх боломж бүрдэхийн зэрэгцээ инфляцийн хүлээлт ямар байхыг тодорхойлж өгдөг байна. Инфляцийн зорилтот шинэ түвшингээ өндөр тогтоож буй Төвбанк зах зээлийг өөрийн бодлогодоо нийцүүлэхийн тулд QE-г ашиглах магадлалтай байдаг. Учир нь бусад зүйл харилцан тэнцвэртэй байж, эргэлт дэх мөнгөн дүн нэмэгдэх нь үнийг хөөрөгдөхөд хүргэдэг. Хэрэв хүмүүс мөнгөний үнэ цэнэ ирээдүйд буурна гэж итгэвэл

энэ нь одоо илүү ихийг зарцуулах түлхэц болж өгдөг байна.

## Бодит дэмжлэг

Цаашдын удирдамж гаргах (forward guidance) нь мөнгөний шинэ бодлогын нөгөө гол хэрэгсэл бөгөөд Төвбанкуудын цаашдын бодлогыг илүү тодорхой болгож өгснөөр эдийн засгийн өсөлтийг дэмжих гэсэн оролдлого юм. Японы Төвбанк 1999 онд анх удаа бодлогын хүүний ханшаа тэг хувь руу ойртуулан буулгахаа амлаж байсан. Тухайн үедээ “Дефляцийн санаа зовоосон асуудал намжих” хүртэл эдийн засгаа дахин сэргээхийг оролдож байв. Түүнээс хойш АНУ-ын Холбооны нөөцийн банк болон Английн Төвбанк энэ арга барилыг дуурайх болжээ. 2009 оны эхэн үеэр Холбооны нөөцийн банкнаас бодлогын хүүний ханшаа доогуур байлгах “хугацаагаа сунгасан” талаар мэдэгдсэн. Мөн 2011 оны наймдугаар сард дээрх томъёоллоо сайжруулах зорилгоор хүүний доогуур ханшийг 2013 оны дунд үе хүртэл хэвээр байлгана хэмээн хугацааг нь тодорхой зааж өгсөн мэдэгдэл гаргасан байна.

Өнгөрсөн оны арванхоёрдугаар сард тус банк дээрх асуудалд дахин өөрчлөлт оруулах болов. Ажилгүйдлийн түвшин 6.5 хувь болж буурах хүртэл хүүний ханшаа доогуур байлгах талаар албан ёсоор зарласан юм. Тухайн үед богино хугацаат инфляци 2.5 хувиас хэтрээгүй байв. Харин энэ оны наймдугаар сард Английн Төвбанк дээрх жишгийг даган ажилгүйдлийн түвшин долоон хувь болж буурах хүртэл бодлогын хүүний ханшаа нэмэхгүй гэсэн мэдэгдэл гаргажээ. Үүний дүнд санхүүгийн зах зээл өөрөө өөрийгөө аваад явах, мөн инфляцийг хөөрөгдөхгүй байх боломж бүрдсэн байна.

QE-тэй төстэйгээр цаашдын удирдамж гаргах (forward guidance) нь хэд хэдэн арга замаар хэрэгждэг байна. Цаашид инфляци өндөр байх асуудлыг шийдвэрлэх тал дээр итгэл, үнэмшил төрүүлэхүйц амлалт өгөх нь өдгөө эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих боломжтой. Үүнийг мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэнээс үүдэн ►

► гарах үнэ хөөрөгдөх эрсдэлтэй адилтгаж болох юм. Үүний нэгэн адилаар богино хугацаат хүүний ханшийг удаан хугацаанд хадгалахаа Төвбанк амласнаар урт хугацаат ханшийг бууруулах боломжтой аж. Тиймээс инфляци нэмэгдэх ба бусад эрсдлийг тооцохын тулд урт хугацаат хүүний ханшийг ерөнхийдөө богино хугацаат ханш болон урамшуулал (premium)-тай хослуулдаг байна.

Түүнчлэн хөрөнгө оруулагчид “бодит” эсхүл инфляциар тохируулсан хүүний ханшид хариу үйлдэл үзүүлдэг бөгөөд үүнийг хүлээгдсэн ямар нэг хүү байхгүй “нэрлэсэн” эсхүл зарласан хүүний ханштай адилтгаж болох. Инфляци сөрөг гарах хүлээлт үүсэх нь үнэ буурна гэсэн утгатай бөгөөд харин бодит хүүний ханш өсөх магадлалтай. Дефляци нь бусад бүтээгдэхүүний нөхцлөөр мөнгөний нэгжийн үнэ цэнийг нэмэгдүүлж, улмаар зээлийн зардлыг ихэсгэдэг. Хэрэв Төвбанк цаашид инфляци үүснэ гэж таамаглаж байгаа бол бодит хүүний ханш бүр тэгээс ч доош буух боломжтой. Нэрлэсэн хүүний тэгээс доош ханш үйлчлэхгүй байгаа нөхцөлд бодит хүүний тэгээс доош ханш харин ч эсрэгээрээ үйлчилдэг байна. Тиймээс бэлэн мөнгө хадгалах нь хамгийн сайн сонголт биш юм. Учир нь инфляци мөнгө болон хадгаламжийн худалдан авах чадварыг бууруулдаг. Тиймээс ч хүмүүс бага хадгалж, харин ихээр зээлж, хөрөнгө оруулах сонирхолтой байдаг аж.

## Онолоос практик руу

QE нь урт хугацаат хүүний ханшийг бууруулсан болохыг энэ талаар хийсэн судалгаанууд харуулжээ. Тухайлбал, 600 тэрбум ам.долларын худалдан авалт нь удаан хугацаат хүүний ханшийг 0.15-0.2 нэгж хувиар бууруулж буй хэрэг. Харин үзүүлж буй нөлөөллийн хувьд энэ нь Холбооны нөөцийн банкны бонгино хугацаат хүүний ханшийг 0.75 нэгж хувиар бууруулсантай дүйх аж. Хүүний ханшийг доогуур байлгаснаар АНУ болон Англид бодит бүтээгдэхүүний гарц (QE-гүй байх ханштай харьцуулахад) 2-3 хувиар нэмэгдэнэ

гэж тооцоолжээ. Гэвч Английн банкуудын хувьд зээлийн зардал эсрэгээрээ өндөр хэвээр байна.

Төвбанкны цаашдын удирдамжийг бэхжүүлэхэд QE нь чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг сүүлийн үед хийсэн судалгаа харуулжээ. Тухайлбал, худалдан авсан зарим төрлийн хөрөнгийн үнэ өөрчлөгдөх болсон нь Холбооны нөөцийн банкнаас үзүүлж буй дохиотой холбоотой юм шиг харагддаг. Цаашид хүүний ханш ямар байх тал дээр аливаа зах зээл итгэлтэй байгаа бол энэ нь бодлогын хүүний ханшаа доогуур байлгах Төвбанкуудын амлалтад хөрөнгө оруулагчид итгэснийг гэрчилж буй хэрэг аж. Гэхдээ Төвбанкууд QE-ийн нөхцлөөр хөрөнгө худалдан авна гэсэн ганцхан нөхцөлтэйгээр.

Үйлдвэрлэлийн гарцыг сайжруулахад тухайн удирдамж (forward guidance) үр дүнтэй байх эсэхийг таамаглахад хэцүү юм. Ирээдүйн бодлогын талаарх мэдээ, мэдээлэл нь урт хугацаат хүүний ханшийг бууруулдаг хэмээн зарим эдийн засагч үздэг. Гэхдээ ханш чухам юунаас болж унадаг нь тодорхойгүй аж. Үүний нэг шалтгаан нь Төвбанкны богино хугацаат хүүний ханшийг доогуур хадгалах амлалтад зах зээлүүд итгэж буйтай холбоотой. Энэ нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, өсөлтийг дэмжих учиртай. Харин нөгөө шалтгаан нь зах зээлүүд Төвбанкнаас гаргасан удирдамжийг зээлийн эрэлт буурч, улмаар эдийн засгийн өсөлт хүлээгдэж буй түвшингээс доогуур байх дохио гэж хүлээж авдаг оршино. Гэхдээ энэ нь шинэ хөрөнгө оруулалтыг хязгаарласан бол сөрөг үр дагавартай гэдэг нь тодорхой юм.

Холбооны нөөцийн банкны сүүлийн үеийн судалгаа эхний үр нөлөө буюу Төвбанкнаас өгсөн амлалтын найдвартай байдал илүү чухал болохыг харуулжээ. Эдийн засгийн цаашдын нөхцөл байдлууд болон тэдгээрээс урган гарах бодлогыг “таамаглах”-аас илүүтэйгээр тодорхой бодлого руу чиглэсэн “үүрэг, амлалт”-ыг тодорхой харуулж байгаа үед удирдамж илүү эрч хүчтэй, жинхэнэ утгаараа хэрэгжих боломжтой гэнэ. Судалгаа,

туршилтын явцад дэлхийн томоохон эдийн засгууд өсөлтөө хадгалахын төлөө тэмцэлдсээр байгаа нь тодорхой болжээ. Тухайлбал, Английн үйлдвэрлэлийн гарц хямралын өмнөх оргил үеийнхээс доогуур үзүүлэлттэй байгаа бол АНУ-ын ажил эрхлэлтийн түвшин 2007 онд хүлээгдэж байснаас 10 саяар буурсан үзүүлэлттэй байх жишээтэй. Харин евробүсийн хувьд давхар уналтат хямрал (double dip recession)-ын хоёр дахь дөнгөнөөс арайхийн мулттраад байгаа боловч ажилгүйдлийн түвшин хоёр оронтой тоотой хэвээр. Товчоор хэлбэл, мөнгөний шинэ бодлого нь уламжлалт бодлого шигээ төдийлэн сайн хэрэгжихгүй байгаа нь харагдаж байна. Гэвч яагаад гэдэг асуулт хариултгүй хэвээр.

Зарим эдийн засагч тэг хувийн хүүтэй тулгарах үедээ мөнгөний уламжлалт болон шинэ бодлого аль аль нь хүчин мөхөстдөг гэжээ. Тухайлбал, Оксфордын их сургуулийн Саймон Рен-Люйс мөнгөний бодлого QE-гүйгээр эдийн засгийг тогтворжуулах боломжгүй хэмээн учирлажээ. Энэ нь Засгийн газрын зардлыг нэмэгдүүлэх эсхүл татварыг багасгах, шинээр үйлдвэрлэсэн мөнгийг зах зээлд нийлүүлэх, бодит эдийн засагт доогуур ханштай хүүг оруулах гэсэн утгатай аж. “Номура” судалгааны хүрээлэнгийн Ричард Күү зэрэг зарим эдийн засагч өр ихтэй компани болон айл, өрх дахин дахин зээл авахаа л бодохоос биш урт хугацаатай, бага ханштай хүүнд эерэг хариу үзүүлэх чадваргүй гэжээ.

Зарим эдийн засагч мөнгөний шинэ бодлогыг Төвбанкууд маш эрчимтэй хэрэгжүүлсэн тохиолдолд л үр дүнгээ өгнө гэж итгэж буй. Японы Төвбанк бодлогын хүүний ханшаа тэг хувь болгосны дараа тухайн үеийн АНУ-ын Принцтоны их сургуулийн эдийн засагч асан, өдгөө Холбооны нөөцийн банкны тэргүүн Бен Бернанке “Японы Төвбанк зорилтот инфляцийн түвшинг илүү өндөр тогтоож, хөрөнгө ихээр худалдан авч, гадаад валют мөн худалдан авч, иенийн ханшаа бууруулах хэрэгтэй” гэсэн байр суурийг илэрхийлж байв. Станфорд их сургуулийн Роберт Холл Холбооны нөөцийн банкны бодлогын хүүний

▶ ханшийг -4 хувь хүртэл бууруулах нь эдийн засгийн өсөлтийн хурдаа нэмэгдүүлэхэд хангалттай гэжээ. Гэхдээ тус банк инфляцийн түвшинг аль болох урт хугацаанд хоёр орчим хувь дээр хадгалаад байвал бодит хүүний ханш -2 хувиас доош буурах боломжгүй юм.

Калифорнийн Беркели их сургуулийн Кристина Ромер нь эдийн засгаа сэргээхийн тулд сэтгэлзүйн доргилт өгөх хэрэгтэй гэж үздэг олон эдийн засагчийн нэг аж. Тэрбээр “дэглэмийн өөрчлөлт” хийх шаардлага байгааг учирлаж буй. Энэ нь зөвхөн манлайлал дахь өөрчлөлт бус, харин бодлогын мэдрэгдэхүйц өөрчлөлт. Түүний бодлоор Төвбанкууд инфляцийг онилохоо больж оронд нь эдийн засаг эсхүл нэрлэсэн ДНБ-ий нийт зардалд анхаарах хэрэгтэй аж. Гэвч ихэнх тохиолдолд дээрх хоёр арга барил аль аль нь төстэй үр дүнг авчрах бөгөөд нэрлэсэн ДНБ-ий зорилт нь огцом уналтын үед ажилгүйдлийн эсрэг тэмцэх илүү боломжийг Төвбанкинд олгож буй хэрэг. Түүний үзэж буйгаар бодлогын өөрчлөлт хийх чухал шаардлагатай бөгөөд энэ нь зах зээлүүдийн хувьд Холбооны нөөцийн банк хурдацтай өсөлтийг дахин авчирна гэсэн дохио болох аж.

Төвбанкуудын зүгээс авсаар ирсэн арга хэмжээг хэтэрхий хангалтгүй хэмээн шүүмжлэгчид байхад хангалттай ихийг хийсэн гэх нэгэн ч байна. Хөрөнгийн үнийг хиймлээр өсгөх нь Төвбанкныхан тэгш бус байдлыг улам өдөөж, санхүүгийн компаниуд өмнө нь ямар алдаа, дутагдал гаргасныг умартан тэднийг мөнгө, санхүүгээр урамшуулан тэтгэж байгаа бөгөөд энэ нь дараагийн хямралын нүхийг малтаж, үрийг суулгаж буй хэрэг хэмээн зарим эдийн засагч гомдоллож буй. Ялангуяа АНУ-ын хувьд мөнгөний нийлүүлэлтийг ихээр нэмэгдүүлэх нь валютын үнэ цэнийг бууруулж, инфляци хяналтаас бүрмөсөн алдагдахад хүргэх аюултай хэмээн олон эдийн засагч сануулж байгаа аж. Зарим эдийн засагч хөгжингүй орнуудад бодлогын хүү доогуур ханштай байх нь шинээр гарч ирж буй зах зээлүүд рүү чиглэсэн гадаад капиталын урсгал (ашиг олох

зорилготой)-ыг ихээр бий болгож, улмаар санхүүгийн тогтворгүй байдал үүсгэх аюултай гэж үзэж буй.

Дээрх санал, шүүмжлэлүүдийн аль нь зөв болохыг цаг хугацаа харуулах биз. 1930-аад онд болсон дэлхийн эдийн засгийн хямралыг улам даамжрахад хүргэсэн зүйл бол мөнгөний буруу бодлого байсан гэдгийг төө хойно 1963 онд Милтон Фрайдман, Анна Шварц нар “АНУ-

ын мөнгөний бодлогын түүх” нэртэй хэвлэл гаргасны дараа л хүмүүс мэдэж авсан түүхтэй. Харамсалтай нь өнөөдрийн мөнгөний бодлогын талаарх маргаантай асуудалд шийдвэрлэх байр суурийг эзэлж буй эдийн засгийн өсөлт олон улс, орны хувьд дунджаас доогуур үзүүлэлттэй байгаа нь гашуун үнэн юм. ■

“The Economist” сэтгүүлээс орчуулав

“ТӨСӨВ-2014”

## “СУРГАМЖТАЙ” ТӨСӨВ



Б.БАЯРТГОХ

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль хэрэгжээд хоёр дахь жилтэйгээ золгох гэж байна. Ямар ч тохиолдолд улсын төсөв малгай хуулийн хязгаарыг гэтэлж болохгүй. Нөгөө талаасаа төсвийг “сахилгажуулах” гэж дээрх хуулийг УИХ баталсан. Хууль хэрэгжсэн эхний жилийн буюу 2013 оны төсөв

хуульд захирагдаагүй нь олон асуудал шүүмжийг дагуулж буй. Зарлага нь оновчтой, орлого нь “хийгүй”, төсөв нь “усгүй” байх аваас тэр жилийн төсөв хуульд нийцсэн гэж хэлж болно. Тэгвэл ирэх оны төсвийн төсөл хуулийн хүрээнд хийгдсэн болохыг Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Э.Батбаяр хэллээ.

Эдийн засаг өсөж, зах зээл хүрээгээ тэлэхийн хэрээр төсвийн орлого, ▶

▶ зарлага нэмэгдэж буй. Гэхдээ төсвийн зарлага хэт данхайж байгаатай санал нийлэх хүн цөөнгүй. Монгол Улсын нийт мөнгөний 40 хувийг эзэлдэг төсвийн алдагдал нь ДНБ-ий хоёр хувиас хэтрэхгүй байх нь төсвийн анхны шалгуур юм. Гэвч энэ оны төсөв дээрх шаардлагыг биелүүлж “сахилгажиг” чадаагүй. Өөрөөр хэлбэл, төсвийн алдагдал ДНБ-ий хоёр хувиас хэтэрч, зургаан хувьд хүрээд буй. Хэрвээ төсвийн гадуурх санхүүжилтийг төсөвт оруулбал алдагдал дээрхээс ч өндөр гарахаар байгаа. Нөгөөтэйгүүр төсвийн орлогыг хэт өөдрөг төсөөлсөн гэж Сангийн яамныхан шүүмжлэлд өртсөн. Ингэж төсвийн орлогыг өндөр тогтоож байгаа нь тулгуур хуулийн зорилгыг гажуудуулах эрсдэлтэй. Төсвийн орлого 1.5 их наядар тасрахад гадаад, дотоод хүчин зүйл давхар нөлөөлсөн. Тиймээс ирэх оны төсөв даруулгатай бас сургажтай төсөв болно гэсэн олон нийтийн горьдлого бий.

Шинэчлэлийн Засгийн газрын хоёр дахь төсөв энэ жилийнхээс орлого, зарлагын хувьд хэмжээ нь ялимгүй буужээ. Гэхдээ бүсээ чангалсан уу гэвэл үгүй. Хэдий эдийн засгийн нөхцөл байдал ороо бусгаа ч төсвийн төсөлд 6.8 их наяд төгрөг олно гэж тооцжээ. Харин зарлагыг 7.2 их наядар баримжаалсан бөгөөд төсөв 410.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байх нь. Тус алдагдалыг Засгийн газрын үнэт цаасаар нөхөх бололтой.

Сүүлийн 10 жилд 2005, 2006, 2007 оноос бусад жилүүдэд төсвийн нийт тэнцэл алдагдалтай явж ирсэн байдаг. Тухай бүрт гадаадын төсөл, хөтөлбөрийн зээл болон дотоодод арилжсан Засгийн газрын бондоор нөхөж ирсэн. Тэгвэл энэ оноос Төсвийн тогтворжилтын сан ажиллаж эхэлснээр цаашид төсвийн алдагдлыг нөхөж тогтвортой байдлыг хангана гэсэн хүлээлт бий. Харамсалтай нь төсвийн орлого тасалдсан нь Тогтворжилтын санд орлого бүрдэхгүй байхад хүргээд байна.

Төсөвт ирэх онд эдийн засгийг бодитоор 14.8 хувиар тэлж, нэрлэсэн дүнгээр ДНБ-ий хэмжээг 20.4 их наяд төгрөгт хүрэхээр төлөвлөжээ. Монгол Улсын эдийн засгийн чадамж бараг л хоёр дахин нугарч, өсөлт одоогийнхоос даруй дөрвөн хувиар хурдаа нэмэх нь. Төсвийн нийт орлого ДНБ-ий 33 хувьтай тэнцэж байна. Улсын төсөв уул уурхайн том ордуудад найдсан хэвээр байна. Тухайлбал “Эрдэнэс Тавантолгой” компани 2014 онд олборлолтын хэмжээгээ 13 сая тоннд хүргэх боломжтой аж. “Оюутолгой” бүрэн хүчин чадлаараа ажиллах бөгөөд 692 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэснээр уул уурхайн салбарын үйлдвэрлэл бодитоор 40 орчим хувиар өсөх юм.

## “Хашир” зарлага

Монгол Улс урсгал зардал дээр цамаан загнаж байсныг дараах тоо гэрчилнэ. Сүүлийн 13 жилийн дотор манай төсвийн зардал хэт томорчээ. Тухайлбал, 2000 онд нийт төсвийн зарлага 430 тэрбум байсан бол энэ онд 7.4 их наяд төгрөг болсон байна. Бараа үйлчилгээний зардал 2000 оныхоос өс дахин өссөн бөгөөд эд хогшил худалдаж авах зардал 5.1 дахин, урсгал засвар 2.7 дахин, гадаад томилолтын зардал найм дахин, хурал зөвлөлгөөн 15.3 дахин өссөн нь гар султайн шинж. “Ирэх оны төсөвт урсгал зардлын өсөлтийг хязгаарлаж, тэвчиж болох зардлыг

хэмнэх, үр ашиггүй зардлыг төсөвт тусгахгүй байхаар зардлын тэлэлтийг хязгаарласан” гэж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Ганбат хэллээ. Гэсэн ч төсвийн зарлага өндөр хэвээр байгааг УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар онцлоод “Ирэх оны нэгдсэн төсвийн тухай хуулийн төсөлд гадаад өрийг 10 их наяд төгрөгт хүргэхээр оруулж ирсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг зөрчихөд хүргэж байна” гэв.

Ирэх оны төсвийн төслийг Засгийн газар УИХ-д оруулж ирэхдээ зарлагыг 169 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн байна. Нэгдсэн төсвийн нийт зарлагыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл 73 хувь урсгал зардал эзэлж байгаа бол 27 хувь нь хөрөнгийн зардал. УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн “Сүүлийн гурван жилийн төсвийн зарлага өмнөх жилүүдтэйгээ харьцуулахад 20-23 хувиар өссөн. Харин 2014 оны төсвийн орлого, зарлагыг эдийн засгийн төсөөлөлтэйгээ уялдуулан бодитой төлөвлөхийг эрмэлзсэн хандлага ажиглагдаж байгаа. Ирэх оны төсвийг төлөвлөхдөө тэвчиж болох, үр ашиггүй 329 тэрбум төгрөгийн урсгал зардлыг танаж төлөвлөсөн байна” хэмээсэн.

Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ жил бүр хэлбэлзэж ирсэн ч сүүлийн арван жил өсөх хандлагатай байна. Энэ хугацаанд төсвийн зарлага хамгийн багадаа ДНБ-ий 33 хувь /2006/, хамгийн ихдээ 48.5 /2011/ онд хүрч байжээ. Тэгвэл ирэх онд ДНБ-ий 35 хувьтай тэнцэх бололтой. Сүүлийн 10 жилийн хугацаанд төсвийн зарлагын өсөлт нь тухайн жилийнхээ эдийн засгийн бодит өсөлт, инфляцийн нийлбэрээс илүү хувиар нэмэгдэж ирж.

Хууль хэрэгжиж эхэлснээр төсвийн алдагдлаа барьж чадахгүй байгаа ч зарлагын тэлэлт хумигдаж, эдийн засгийн бодит өсөлт болон инфляцитай уялдах эхлэл тавигдсан сайн тал бийг хэлэх хүн ч байна.

Ирэх онд цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлэхээр 200 орчим тэрбум төгрөгийг “хавчуулжээ”. Мөн Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад сар бүр олгож буй 45 мянган төгрөгийг 70 мянган төгрөг болгож өсгөхөөр суулгасан байна. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулсан 70 гаруй мянган хүнд 31 тэрбум төгрөг олгохоор тусгаж. Мөн арьс ширний урамшуулалд төсвөөс 20 тэрбум төгрөгийг өгөхөөр тус тус төлөвлөсөн байна.

Дэлхийн банкны тайлангаас үзэхэд манай улсын төрийн албаны цалин сүүлийн таван жилд бүхэлдээ тогтмол 15-30 хувиар нэмэгдсэн боловч хувийн салбарын цалингийн өсөлттэй зэрэгцэж чадаагүй байна. Нэрлэсэн цалингийн хэмжээ 2003 оноос хойш долоо дахин нэмэгдсэн нь төсвийн том дарамт болж буй. Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Б.Батцэцэг “Ирэх оны төсвийг бид тийм ч өөдрөг төсөөлөхгүй байгаа. Ерөөсөө л суурь орлогынхоо түвшинд төлөвлөсөн” гэв.

## Орлого яадаг бол...

Төсвийн төсөлд өгүүлснээр ирэх онд манайх чамгүй нүүрс экспортолж, шархаа нөхөх бололтой. Төсөвт “Оюутолгой” компани 161.5 тэрбум төгрөгийн орлогыг, “Эрдэнэт” үйлдвэр ▶

▶ 187.7 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлэх аж. “Эрдэнэт” үйлдвэр 502 мянган тонн зэсийн баяжмал, 3.2 сая тонн молибдены баяжмал олборлох юм байна. Төсөлд тусгаснаар зэс, нүүрсний үйлдвэрлэлээс төсөвт төвлөрөх орлогыг 206.8 тэрбум төгрөг буюу нийт орлогын гурван хувиас давна гэж үзжээ. Ирэх онд төсөвт зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 6.242 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг чанараас хамааруулан тонн тутамд 81.6-115.9 ам.доллар байхаар тус тус таамаглажээ. Уул уурхайн салбараас ирэх онд нийт 1.4 их наяд төгрөгийн орлого төсөвт төвлөрөх аж. Үүний 41 хувийг нүүрс, 27 хувийг зэсийн үйлдвэрлэл дангаараа эзэлж байна.

Төсвийн нийт орлогын 90.7 хувь буюу 6.2 их наядыг татварын орлогоор бүрдүүлэх бол үлдэж буй 9.3 хувь буюу 637 тэрбум төгрөг нь татварын бус болон хөрөнгийн орлогоос бүрдэх юм. Төсвийн орлогыг гол бүрдүүлэгч Татварын ерөнхий газар ирэх онд 3.3 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэх бол энэ нь нэгдсэн төсвийн нийт орлогын 48.4 хувьтай тэнцэж байна. Харин Гаалийн ерөнхий газар төсөвт 1.9 их наяд төгрөгийн орлого бүрдүүлэх үүрэг авчээ. Бүтээгдэх баялгийн 100 төгрөг тутмын 33-ыг төр дахин хуваарилна. Өөрөөр хэлбэл, төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 33 хувь байхаар төсвийн төсөлд тусгасан. Уг харьцаа нь төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон дүн бөгөөд гол нэрийн түүхий эдийн үнэ өсөхийн хэрээр эзлэх хувь нэмэгдэх аж.

Аливаа Засгийн газрын орлогын гол эх үүсвэр нь татвар ч гэлээ нийт орлого дахь татварын орлогын эзлэх хувь хэт өндөр байгаа нь орлогын тогтворгүй байдалд нөлөөлж байгааг судлаачид хэлдэг. Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага /OECD/-ын гишүүн орнуудад татварын орлого нь дунджаар төсвийн орлогын 60 гаруй хувь байгаатай харьцуулахад Монгол Улсын төсвийн орлого маш эмзэг гэсэн үнэлгээг аваад буй. Товчхондоо орлогын эх үүсвэр зөвхөн шууд татвараас бүрдэж байна. Энэ байдал нь эдийн засаг дахь татварын ачаалалд давхар нөлөө үзүүлсээр. Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн үнээр тооцож эхэлсэн ч төсөв бүхэлдээ нэг салбараас хамаарах байдал хэвээр байгааг харуулж байна.


Манай улсын нүүрсний экспорт бүхэлдээ БНХАУ-руу гарч байгаа. Ирэх онд манай улс урд хөршдөө 31.4 сая тонн нүүрс экспортолно гэж төсөвт тооцжээ. Энэхүү нүүрсний хэмжээ нь Хятадын коксжих нүүрсний импортын 41.9 хувьтай тэнцэж буй. Нүүрсний экспортын өсөлтөд “Эрдэнэс Тавантолгой”, “Саусгоби сэндс” голлон нөлөөлөх аж. “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьд Баруун, Зүүн Цанхийн хэсгээс зэрэг нүүрс экспортлохоор байгаа нь нүүрсний экспортыг ихээхэн нэмэгдүүлэх бол “Саусгоби сэндс” компанийн хувьд ирэх оноос үйл ажиллагаагаа эрчимжүүлэх аж.

Нүүрс, зэсэнд уяатай Монголын Улсын ирэх оны төсвийн орлого хэрхэх нь дэлхийн зах зээлээс хамаарах юм. Үүнд БНХАУ-ын эдийн засаг ч давхар нөлөө үзүүлнэ. Экспортын гол нэрийн түүхий эдээс 2014 онд үнэ нь харьцангуй тогтвортой байх магадлалтай түүхий эд алтыг эс тооцвол зөвхөн зэсийн баяжмал гэж шинжээчид дүгнээд буй. Ирэх онд уул уурхайн орлогын дийлэнхийг нөөц ашигласны

### Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд

	2012	2013*	2014**	2015**	2016**
ДНБ, оны үнээр, тэрбум төгрөг	14,013	17,000.3	20,503.1	24,494.8	29,317.0
ДНБ, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг	5,498.5	6,310.6	7,244.4	8,405.2	9,650.0
Эдийн засгийн бодит өсөлт	12.4	14.8	14.8	16.02	14.81
Хөдөө аж ахуй	21.6	16.5	6.2	9.1	12.1
Үйлдвэрлэл	9.9	26.8	26.3	29.2	26.2
Үйлчилгээ	16.3	9.8	13.5	13.3	10.5
Уул уурхайн	8.0	22.3	40.0	38.0	28.7
Уул уурхайн бус	13.2	13.4	9.8	10.5	10.4
Ам.долларын жилийн дундаж ханш	1,359.2	1,450.0	1,384.0	1,279.0	1,251.9
Гадаад худалдааны тэнцэл	(2,354.2)	(1,660.8)	507.0	1,155.2	1,370.2
Экспорт, сая ам.доллар	4,384.6	4,686.3	7,237.0	8,502.5	8,806.8
Импорт, сая ам.доллар	6,738.8	6,347.2	7,383.0	7,347.3	7,436.6
Хэрэглээний үний өөрчлөлт, оны эцэст	14.0	8.0	6.0	6.0	6.0

### Уул уурхайн экспорт, мянган ам.доллар



Хүснэгт 14. Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тэрбум төгрөг

Орлого	2012	2013	2014
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Төсөл
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дун	4,881.2	7,088.2	6,865.0
1 Татварын орлого	4,203.3	6,461.5	6,227.1
1.1. Орлогын албан татвар	871.4	1,261.5	1,283.6
1.2. Нийгмийн даатгалын орлого	674.2	732.0	1,085.9
1.3. Өмчийн татвар	21.9	23.7	33.3
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,296.5	1,940.2	1,702.4
1.5. Онцгой албан татварын орлого	312.4	595.2	597.7
1.6. Тусгай зориулалтын орлого	34.0	37.3	46.0
1.7. Гадаад үйл ажиллагааны орлого	327.4	575.3	426.2
1.8. Бусад татвар(төлбөр, хураамж)	665.6	1,296.3	1,051.9
2 Татварын бус орлого	642.7	625.8	637.4
Хөрөнгийн орлого	10.4	0.8	0.5
Тусламжийн орлого	24.7	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

төлбөр бүрдүүлэхээр байна. Тус салбараас төсөвт орж буй орлогын бараг 60 гаруй хувийг нөөц ашигласны төлбөр болон өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр бүрдүүлэх аж. Төсвийн хоёр дахь шатны хэлэлцүүлэг өрнөсөөр. Ирэх онд ямар төсөвтэй болох нь хараахан тодорхой болоогүй байна. Сургамжтай төсөв батлаасай гэж найдъя. ■



Л.БЯМБААГИЙН БУЛАН

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭХЛЭЛ ТАВИГДЛАА

## Хуулийн талаар

Монголд анх удаа Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль энэ сарын эхээр батлагдлаа. Энэ нь манай улсын эдийн засаг, санхүүгийн салбарын ирээдүйд нэн чухал ач холбогдол бүхий үйл явдал юм. Учир нь, манай бодит эдийн засгийн болон хувийн хэвшлийн хөгжил тодорхой нэг түвшинд хүрээд зогссон, харин дараагийн шинэ шатанд гарахад санхүүгийн салбарын, нэн ялангуяа хөрөнгийн зах зээлийн хөгжил хоцрогдоод байсан гэж хэлж болно. Хөрөнгө оруулалтын сан (ХОС)-гийн тухай хууль батлагдснаар санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг зөв голдиролд нь оруулах үндэс суурь тавигдаж байгаа юм.

Санхүүгийн зах зээлд санхүүжилтийн нэмэлт, удаан хугацааны эх үүсвэртэй болох, зах зээлийг илүү зохион байгуулалттай, мэргэжлийн, зохих зохицуулалттай, хариуцлагатай болгох, нөгөө талаас иргэд эдийн засгийн өсөлтөөс хүртэх боломжийг нээх, хөрөнгө оруулалтын

шинэ сонголтуудыг бий болгох, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах механизмыг бүрдүүлж, системийн эрсдэлийг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой байх болно.

Уг хууль нь ХОС-г үүсгэн байгуулах, санд тусгай зөвшөөрөл олгох, сангийн хөрөнгийг удирдах, сангийн хөрөнгийг хадгалах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зэрэг суурь харилцааг зохицуулах зорилтыг агуулж буй.


## Хөрөнгө оруулалтын сангийн төрөл

Сан	Санг бүрдүүлэх орлого	Сангийн зориулалт	Сангийн хугацаа
Хөрөнгө оруулалтын сан	Иргэд, компанийн орлого	Хувьцаа, багцын хөрөнгө оруулалт	Богино, дунд
Хувийн тэтгэврийн сан	Ажилтан, ажил олгогчийн шимтгэл	Тэтгэврийн хуримтлал	Удаан
Хувийн хөрөнгө оруулалтын сан	Мэргэжлийн хөрөнгө оруулагч Төсөв ЖДҮ дэмжих төсөл	ЖДҮ-ийг томруулах, үйл ажиллагааг нь тэлэх, ХХК	Дунд
Венчур сан	Мэргэжлийн хөрөнгө оруулагч	Гарааны компаниуд	Дунд
Хедж сан	Ашигт малтмалын орлого	Эрсдэл өндөр, эрсдэл тараан байршуулах	Богино, дунд

## Санхүү, хөрөнгийн зах зээлд гарах өөрчлөлт

Аливаа зах зээл бараа бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт дээр тогтдог бөгөөд тухайн зах зээлийн тоглоомын дүрэм тодорхой байх ёстой. Энэ зарчим хөрөнгийн зах зээлийн тухайд ч нэгэн адил үйлчилнэ. Хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн буюу нийлүүлэлт хувьцаа гаргагч буюу ХК-иудиар илэрхийлэгдэнэ. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль өнгөрсөн хавар шинэчлэгдэн батлагдсан нь нийлүүлэлт талыг нэлээд сайн цэгцэлж өгсөн. Харин худалдан авагч тал буюу эрэлт талыг ХОС-гийн тухай хуулиар бүрдүүллээ гэж хэлж болно. Аль аль хууль нь 2014 оны нэгдүгээр сараас мөрдөгдөж эхлэх тул хөрөнгийн зах зээлд үр ашигтай ажиллах суурь боломж бүрдэж байна гэсэн үг.

Цаашилбал, хөрөнгийн зах зээл зөв хөгжиж эхэлбэл, эдийн засгийн өсөлтийг дэмжих оновчтой, ►



► урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр бүрдэнэ гэсэн үг. Банкны зээлээр санхүүжих боломжгүй, барьцаа хөрөнгөгүй эхлэлийн компани, төслүүд тусгай зориулалтын хөрөнгө оруулалтын сангаас санхүүждэг. Мэргэжлийн түвшинд сайн судалгаа, шинжилгээ хийгдэх тул үйлдвэрлэлийн салбаруудыг дэмжиж, эдийн засгийн өсөлт шинэ шатанд гарах боломжтой болно.

Нэгэнт мэргэжлийн, байгууллагын хөрөнгө оруулагч болдог тул ХОС нь хүчтэй тоглогч болж чаддаг. Тус сан нь хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг ямагт хамгаалж ажилладаг тул компанийн засаглалын асуудалд хүчтэй нөлөө үзүүлж чаддаг. Нэг хүнээс хараат, дотоод хяналт болон эрсдэлийн удирдлага сул компаниудад тодорхой шахалт үзүүлж засаглалыг нь сайжруулж өгдөг.

ХОС-гаар дамжин бас нэг чухал механизм бүрдэж байгаа нь орлогын хуваарилалтын суваг юм. Санхүүгийн салбарын шинээр үүсч буй дэд бүтцээр дамжуулан эдийн засгийн өсөлт, баялгийн хуваарилалтыг шударга, үр ашигтай, оновчтой байдлаар хийх боломжтой болж хэтдээ нийгэмд чинээлэг дундаж анги тэлэхэд түлхэц үзүүлнэ.

Энэ бүгдийн үр дүнд санхүүгийн салбарт банк давамгайлсан байдал аажмаар буурч, системийн эрсдэл

багасаж илүү тогтвортой орчин бүрдэж байгаа юм.

### Хөрөнгө оруулалтын сангийн ажиллах зарчим

Олон хүмүүсийн хувьд Хөрөнгө оруулалтын санг хадгаламж зээлийн хоршоод шиг болох вий гэж болгоомжлоод байгаа. Өөрөөр хэлбэл, маш олон хүний мөнгийг бөөгнүүлж, хувьцаа худалдаж аваад, тэгээд дампуураад, алга болох вий гэж харж байгаа. Өмнөх алдаанаас суралцаж, дахин гаргахгүй байх үүднээс хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамаагалах, эрсдэлийг бууруулах үүднээс хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны хяналтыг бүх шатанд тавих боломжтой байх үндсэн зарчим хуульд сууж өгсөн. Үүнд, хөрөнгө оруулагч өөрөө, талуудын төлөөлөл орсон зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо, тухайлсан хадгаламжийн байгууллага болох кастодиан, аудит зэрэг талууд тус бүрийн үүргийн хяналтын тогтолцоонд гүйцэтгэж хэрэгжүүлэх юм.

Сангийн хөрөнгө оруулалтын удирдлагыг мэргэжлийн шаардлага хангасан, тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгө оруулалтын менежментийн компани хийх бөгөөд сангийн

хөрөнгийг тусдаа дансанд байршуулж кастодиан банкинд хадгалуулна.

### Иргэд, хөрөнгө оруулагчийн хувьд ач холбогдол

Ард иргэдэд хөрөнгө оруулалтын шинэ сонголтыг бий болгож байгаа гэж ойлгож болно. Өөрт байгаа боломжит хөрөнгөөр нэгдээд хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан хамтран хөрөнгө оруулалтууд хийж, тухайн хөрөнгө оруулалтын өгөөжөөс хүртэх боломж нээгдэж байгаа.

ХОС-гаар дамжуулж хөрөнгө оруулалт хийх нь иргэдийн хувьд нэг талаар заавал өөрөө зах зээлийг ажиглаж, дүн шинжилгээ хийхгүйгээр цаг хэмнэх бөгөөд нөгөө талаар мэргэжлийн үйлчилгээ авч байгаа, мөн хөрөнгө оруулалтыг тархаан байршуулах замаар эрсдэлээ бууруулж байгаа гэсэн үг. Жишээ нь, иргэдийн хувьд хуримтлал нь инфляцид идэгдэх, эсвэл валютын ханшийн савалгаанаас болж буурах тохиолдол гардаг. ХОС-д нэгдэх замаар хөрөнгө оруулалт хийвэл харин мэргэжлийн багийн үйлчилгээ авч олон талын эрсдэлээ хаах боломжтой болох юм. ■

Э.ЗОРИГТ

ЯРИЛЦЛАГА

*“МН” группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхантай БНАСАУ-ын аж байдал, эдийн засгийн өнөөгийн төрх, бизнесийн боломж гээд олон сонирхолтой сэдвийн хүрээнд ярилцсан юм.*

**-Ярилцлагынхаа эхэнд таны Хойд Солонгос руу ямар зорилгоор аялсан талаар сонирхъя?**

-Өнгөрсөн жил БНАСАУ-ын Худалдаа аж үйлдвэрийн танхмын урилгаар Монголоос хэдэн хүн Хойд Солонгос руу явсан. Энэ урилгын зорилго нь Хойд Солонгосын компаниуд Монгол Улсын хувийн хэвшилтэй хамтран ажиллах боломжийн талаар ярилцах, харилцан ойлголцох байсан юм. Хоёр орны бизнесийн хамтын ажиллагааны талаар биднийг тус улсын холбогдох яамдын сайд, хувийн хэвшлийн төлөөлөл хүлээн авч уулзсан. Тэдний ярианаас сонсоход ер нь хойд солонгосчууд монголчуудтай хамтран ажиллах сонирхол ихтэй байгаа нь ажиглагдаж байлаа. Тиймээс тус улсад томилолтоор очсон хүмүүс Монголдоо ирээд нэг баг болж, “Монгол-Зүүн Азийн хамтын ажиллагааны зөвлөл”-ийг байгуулсан юм.

**-Зөвлөл юу хийх вэ?**

-Энэ зөвлөлийг байгуулсан нь учиртай. Хойд Солонгосын газар зүйн байршлыг харахаар монголчуудад бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж нээлттэй болж байгаа юм. Тиймээс энэ нь нэг талаар далайд гарцгүй Монгол шиг орны хувьд геополитикийн том боломж юм. Нөгөө талаар хойд солонгосчууд манай улстай хамтран ажиллахаас гадна Монгол Улсаар дамжуулж дэлхийн өөр оронтой харилцах арга замыг хайж байх шиг. Тэр ч утгаараа манай зөвлөлийн шугамаар Хойд Солонгосын дөрвөн ч компанийн төлөөлөл Монгол Улсад айлчилж, бизнесийн хамтын ажиллагааны янз бүрийн боломжийн талаар ярилцсан. Үүний үр дүнд тус улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимаас энэ онд дахин урилга ирүүлж, манай “Монгол-Зүүн Азийн хамтын ажиллагааны

# ХААЛТТАЙ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ХААЛГА



Фотог Э.Зоригт

зөвлөл”-ийн гишүүд дахин нэг удаа Хойд Солонгост бизнесийн уулзалт хийх боломж олдсон юм. Энэ үеэр тус улсын хамгийн том

баяр болох Ялалтын 60 жилийн ойн баяр тохиож байлаа. Төр засгаас нь тухайн баярт өндөр ач холбогдол өгдөг юм билээ. Ард иргэд нь ч ▶

ялгаагүй баярыг их хүндэтгэлтэйгээр тэмдэглэдэг нь ажиглагдсан. Бидэнд мэдээлснээр Ялалтын 60 жилийн ойн баярын хүрээнд гаднын 70 гаруй орны төлөөлөл ирсэн гэж байсан. Биднийг явж байхад нэг сонин зүйл ажиглагдсан нь Монголын 100 гаруй жуулчин Хойд Солонгост аялж таарсан.

**-Хойд Солонгосыг дэлхий нийт улс төрийн бодлого нь хатуу, эдийн засгийн хувьд ядуу буурай орон гэж төсөөлдөг. Ард иргэдийн үзэл бодол нь төрийн бодлогын уршгаар дэлхий нийтийн жишгээс хол хөндий гэх нь ч бий. Тэгвэл бодит байдал дээр бидний төсөөлөл хэр үнэний хувьтай байдаг вэ?**

-Бид ч гэсэн ямар орчинд очих бол гэсэн хүлээлттэй байлаа. Ер нь бид Хойд Солонгосын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр юу гаргана түүгээр л төсөөлдөг шүү дээ. Чиний хэлдгээр ард иргэд нь ядуу буурай, гудамж нь хүнгүй гэх мэтийн л төсөөлөлтэй очсон. Гэтэл төсөөлж байснаас огт өөр орчин угтсан. Гудамж талбай нь цэвэрхэн, хийц загвар сайтай өндөр барилга олон. Сүүлийн үеийн загварын тансаг зэрэглэлийн машин зөрөлдөж, яг л хөгжиж буй орны жишгээр хөгжиж байгаа орон юм билээ. Мөн иргэдийнх нь амьдрал бидний төсөөлдөг шиг тийм ч дор орчихоогүй. Хоолны үнэ нь манай Улаанбаатараас ялимгүй хямдхан. Өмсөж, зүүж байгаа нь бусдын дор орохооргүй цэвэрхэн, аятайхан. Хэдийгээр улсаас валютын ханшийг тогтоодог хэдий ч албан бус ханшаар ам.доллар, юань зэрэг валют чөлөөтэй хөрвөдөг, худалдаа хийж болдог. Ингээд харахаар Хойд Солонгосын бодит байдал бидний нийтлэг төсөөллөөс арай өөр л дөө.

Биднийг хоёр их удирдагчийнхаа бунхан руу оруулсан. Бунханд удирдигчдынхаа авч байсан шагнал урамшууллыг үзмэр болгоод тавьчихсан байдаг юм билээ. Гэтэл тэнд Сүхбаатарын одон, Энхтайван найрамдлын хорооноос өгсөн дурсгалын зүйл, Хойд Солонгосын төлөөллүүд манай Ж.Батмөнх даргатай хийж байсан уулзалтын зураг гээд хоёр орны түүхэн харилцааг харуулах олон сайхан эд

өлийн зүйлийг бодитоор нь харж сэтгэл хөдөлсөн.

**-Тус улсын бизнесмэнүүд манай улстай ямар салбарт хамтран ажиллах сонирхолтой байна вэ?**

-Хойд солонгосын бизнесмэнүүд манай улсын хөрөнгө оруулагчдыг уул уурхай, худалдаа, дэд бүтэц тэрбүү хэл, нефтийн бүтээгдэхүүний салбарт хамтран ажилламаар байна гэдэг санал тавьсан. Дээрээс нь тус улс өөрийн гэсэн өндөр технологийг бий болгож чадсан байна. Тиймээс тэр өндөр технологио Монголд нэвтрүүлэх сонирхолтой юм билээ. Түүгээр зогсохгүй манай улсаас уул уурхайн болон хүнсний бүтээгдэхүүн авах ч сонирхол их байдаг юм байна. Гэхдээ энэ мэт харилцан ашигтай сонирхол байгаа ч ажил хэрэг болгоход учирч болох хэд хэдэн томоохон саад байна. Хамгийн түрүүнд тулгамдаж байгаа асуудал нь тээвэр, логистикийн асуудал. Дараагийн том асуудал нь худалдаа, үйлчилгээний дэд бүтэц буюу банк хоорондын гүйлгээний асуудал орно. Тухайлбал, Монголын нэг бизнесмэн Хойд Солонгос руу бараа ачууллаа гэхэд төлбөр тооцоогоо хэрхэн хийх вэ гэдэг маш хүнд асуудал. Ардчилсан Солонгосын хувьд цөмийн бөмбөгтэй бүс нутаг учраас олон улсын хэмжээний томоохон хоригт орчихсон байдаг. Энэ нь харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд зарим талаар саад болж байна. Гэхдээ давуу тал бас бий. Монголчууд 1990-иэд оны эхээр гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд хууль эрх зүйн орчноо зөөллөж, өөрийн орныг сурталчилах гээд олон ажил хийж байсан шүү дээ. Яг л үүнтэй адилхан Ардчилсан Солонгосын төр, засгаас хөрөнгө оруулагчдыг хамгаалах, татах бодлого явуулж байна. Энэ нь бидний хувьд нэг талаар боломж юм. Үүнээс гадна тус улсын төр засаг, хувийн хэвшил нь манай улстай хамтран ажиллах чин хүсэлтэй байгаа нь юу юунаас чухал. Дээр дурдсан томоохон эрсдэл байгаа ч гэсэн шийдэх арга бас бий.

**-Хойд Солонгосын тал Монголоос хөрөнгө оруулалт татах сонирхолтой байна гэлээ. Тэдний хувьд биднээс ямар давуу**

**талыг харж, Монголын өрсөлдөх чадварыг хэрхэн үнэлсэн юм бол.**

-Тус улсын хувьд цаад талаараа буюу Европ, Америктай төмөр хөшгөөр тусгаарлагдчихсан гэж хэлж болно. Товчхондоо барууны ертөнц тэдний хувьд хаалттай. Дээрээс нь тус улсын нийт хүн ам 24 орчим сая хэдий ч Хятад улстай харьцуулахад харьцангуй жижиг улс. Тийм болохоор монголчуудын байнга сэрэмжилж байдаг шиг нэг улсаас хэт хамааралтай болохоос сэрэмжилдэг байдал мөн ялгаагүй Хойд Солонгост байна. Яг ийм үед тус улстай хамтын ажиллагаа тогтоож болох гуравдагч хөрш буюу хамгийн аюулгүй түнш нь Монгол Улс болоод байх шиг байгаа юм. Учир нь манай улсын эдийн засаг хурдтай хөгжиж байна. Газар зүйн байршлын хувьд ашигтай. Дээрээс нь хоёр улсын уламжлалт түүхэн харилцаа сайн. Одоогийн улс төрийн харилцаа ч сайн байгаа гээд тоочоод байвал олон давуу тал бий. Энэ дундаас хамгийн чухал нь Хойд солонгосчуудтай нэг түвшинд харьцах хамгийн боломжит түнш магадгүй монголчууд байж болох юм. Хэрвээ Ардчилсан Солонгос, Хятад улстай хамтын ажиллагаа тогтоолоо гэхэд улс төрөөс эхлээд олон асуудал үүсч магадгүй. Тиймээс аль болох нэг түвшинд харьцаж болох, харилцан ашигтай хамтран ажиллах түнш л тэдэнд хэрэгтэй байгаа юм. Ер нь тус улсын гадаад харилцааны бодлогыг ганцхан зүйлээс харж болох юм шиг. Тухайлбал, томоохон үйл явдал болоход өөрийн улсад байгаа тэр олон Элчин сайдуудаас Хятад, Орос, Монгол, Вьетнам гэсэн улсын Элчин сайд нарыг заавал урьдаг юм билээ.

**-Хойд Солонгосын хувьд ийм давуу тал байгаа юм байна. Харин хоёр орны хамтын ажиллагааг өргөжүүлэх нь манай улсад ямар ач холбогдолтой вэ?**

-Би хувьдаа ажигласан нэг зүйл бол "Rason" гэх боомт жилийн дөрвөн улирлын турш нээлттэй байдаг. Энэ нь тус улсын болоод манай улсад олон давуу талыг бий болгоно. Монголчуудын нэг зорилго уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнээ өндөр үнэтэй, багтаамж сайтай гуравдагч зах зээлд экспортлох ▶

байдаг. Тухайлбал, Япон, Солонгос зэрэг улсад нүүрс экспортлох сонирхол бидэнд бий. Гэтэл Монголд дэд бүтэц нь алга. Тийм болохоор дээр дурдсан жилийн дөрвөн улиралд нээлттэй байдаг тус улсын боомтоор Монголын нүүрс Япон, Солонгост хүрэх боломжтой. Нөгөө талаасаа Хойд Солонгост манай улсаас уул уурхайн бүтээгдэхүүн авах эрэлт байна. Дэлхийн олон улсад уул уурхайн бүтээгдэхүүний хэрэгцээ байгаа. Харин монголчуудад олон улсад нүүрсээ зарах сонирхол байгаад байдаг. Гэтэл дэд бүтэц байхгүй учраас энэ мөрөөдөл гацаанд орчихдог нь өнөөгийн бодит байдал. Тэгвэл Хойд Солонгост байгаа хэрэгцээг хангах замаар бусад улсад гарах үүд хаалга бидэнд нээгдэж болох юм.

**-Та дээр дурдсан. Тус улсын зарим технологи өндөр хөгжсөн талаар. Тэгвэл ямар технологийг манай улсад нутагшуулах боломжтой байна вэ?**

-Тус улсын нано технологийн хөгжил өндөр түвшинд хүрчихсэн байна. За тэгээд газар тариалан, тахиа шувууны аж ахуй гээд хөдөө аж ахуйн салбарын хөгжил нь манай улсыг дагуулахааргүй. Ер нь өндөр хөгжсөн салбарыг нь энд ярихаас илүүтэй бодит байдал дээр нь илүү сайн судлах юм бол их зүйл гарч мэднэ.

**-БНАСАУ-ын улс төрийн амьдралын талаарх мэдээлэл дэлхий нийтийн хувьд харьцангуй сайн байдаг. Гэтэл эдийн засгийн мэдээлэл нь хаалттай. Тэгвэл тус улс өнөөдрийг хүртэл эдийн засгаа ямар салбараараа дэмжиж ирсэн байна вэ?**

-Хойд солонгосчуудын мөрддөг "Чүчхэ"-гийн онол гэж бий. Тэр нь бүгдийг бид дотооддоо хийж чадна гэсэн ерөнхий агуулгатай байдаг. Энэ онолынхоо хүрээнд дотооддоо үйлдвэрлэх замаар ард иргэдийнхээ хэрэгцээг хангачихаад байх шиг байгаа юм. Мөн уул уурхайн баялагаараа Өмнөд Солонгосыг дагуулахааргүй арвин нөөцтэй. Тиймээс ойрын ирээдүйд тус улсын эдийн засгийг чирэх гол салбар нь уул уурхай байх болов уу. Түүнээс гадна

далайн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл тус улсад сайн хөгжсөн. Манай улсыг бодвол 24 сая хүн амтай гэдэг чинь дотооддоо том зах зээл. Хэрвээ эдийн засгийн бодлогоо нээлттэй болгож чадвал тус улсыг тойроод том зах зээл, том эрэлт их бий.

**-Таныг Хойд Солонгост эхний удаа очиход улс төрийн савлагаа, шинэ удирдагчаа сонгох гээд бөөн юм болж байсан байх. Харин энэ удаа шинэ удирдагч гараад ирчихсэн. Улс төрийн хувьд арай өөр бодлого явуулж байгаа нь олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсаар байна. Энэ талаар танд мэдрэгдсэн зүйл**

**байна уу?**

-Миний хувьд ажиглагдсан зүйл бол тус улсын улстөрчдөөс эхлээд нөлөө бүхий бүх хүн эдийн засгаа хөгжүүлэхэд ихээхэн анхаардаг болсон. Эдийн засгаа хэрхэн хөгжүүлэх вэ, хэрхэн олон улсад өрсөлдөх чадвартай болох вэ гэдэг талаар дор бүрнээ толгойгоо гашилгаж байна. Тиймээс энэ боломжинд тулгуурлаад бид хамтран ажиллах хэрэгтэй. Ер нь бидний хувьд тус улсын улс төрийн бодлогыг сайн, муу гэж дүгнэх нь тийм ч таатай санаа биш. Харин эдийн засгийн бодит боломжийг нь харилцан ашигтай хамтран ашиглах л хэрэгтэй. ■

ХӨРШ

## ХЯТАДЫН ШИНЭ ЭДИЙН ЗАСАГ

Б.ТОГТОХ

**Х**ятад. Бидний сайн мэдэх атлаа Хнээж амжаагүй ертөнц. Тэд өдгөө дэлхийн эдийн засгийн төв цэг болохын зэрэгцээ Зүүн Ази, Номхон далайн бүсийн хэтийн ирээдүйг тодорхойлж байна. Нээлттэй бодлогын үр дүнд 30 жилийн турш эдийн засаг нь дунджаар 9.9 хувиар цахилсан Хятадын өсөлт 2011 оноос улирал дараалан саарлаа. Өсөлтийн эрчээ алдах Хятад шинэ эдийн засгийн бодлого хэрэгжүүлэхээр зэхэж байна. Амсхийх өмнөд хөрш өсөлтөд хууртах бус дотоодын эрэлтэд тулгуурлаж, эдийн засгийн бүтцээ солихоор ийн адгаж буй. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн шинэчлэлийн бодлогоо алхам алхмаар түлхсээр.

Дэлхийд хоёрдугаарт жагсах том

эдийн засагтай орны хувьд өсөлт удааширсан нь улс төрийн бодлоготой ч холбоотой байсныг дээрх шинэчлэл гэрчилнэ. Зүүн Азид төдийгүй дэлхий нийтэд танил болсон "Хятадын загвар" домог болж, дахин шинийг тэд сэдсэн нь бүтцээ орвонгоор нь эргүүлэх явдал. Өөрөөр хэлбэл, гадаад эрэлтэд бус дотоодын зах зээлийн нөөц бололцоонд түшиглэхийг тэд илүүд үзэв. Учир нь өнгөрсөн оноос эхэлж, Хятадын гадаад худалдаа алдагдал хүлээхийн сацуу экспортын орлого дорвитой өсөөгүй нь урьдын зүйл ул болоход хүргэсэн гэх.

Хүн үргэлж шинэ зүйлд тэмүүлж байдаг. Үүнтэй адил Хятадын ард түмэн өөрчлөлт, шинэчлэлтийг хүссэн хэрэг. Хятадын ажилчдын хөдөлмөрийн бүтээмж гурав дахин нэмэгдсэн ч цалин нь дөнгөж хоёр дахин өссөн нь өөрчлөлтийн салхийг



## Өөрчлөлтийн өмнө

“Хятад улс экспортод чиглэсэн эдийн засгаас дотоодын эрэлтэд суурилсан эдийн засагт анхаарах болсон тул Зүүн Азийн хөгжингүй орнуудын өсөлтийг сааруулахад хүргэж байна” хэмээн Зүүн Ази, Номхон далайн бүсийн тоймд өгүүлжээ. Нөгөө талаасаа хөрөнгө оруулалт буурсан, дэлхийн зах зээл дээрх түүхийн эдийн үнэ унасан, экспортын хувь хэмжээ төлөвлөж байснаас бага гарсан нь тус бүс нутгийн өсөлтөд нөлөөлсөн аж.

Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн бүсийг хариуцсан дэд ерөнхийлөгч Аксел ван Тротсембург “Зүүн Ази, Номхон далайн бүс нь дэлхийн ДНБ-ий 40 хувийг бүрдүүлж, дэлхийн эдийн засгийн хөдөлгөгч хүч хэвээр байна. 40 хувь гэдэг өөр бусад бүс нутагт байхгүй үзүүлэлт” хэмээн онцлоод Хятадын бүтцийн өөрчлөлтийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн юм. Ганц Хятад ч бус дэлхийн ерөнхий эдийн засгийн өсөлт хурдасч буй тул эдийн засгийн өсөлтөө хадгалах, ядуурлыг бууруулах, мөн ядуу, эмзэг бүлгийн иргэдийн амьдралыг дээшлүүлэх үүднээс хөгжингүй орнууд бодлого болон бүтцийн өөрчлөлт хийх цаг болсныг Аксел ван Тротсембург тайлбарласан билээ.

Хятад Зүүн Азийн нэгэн эд эс. Зөвхөн эд эс байгаад зогсохгүй эдийн засгийн “мотор” гэж хэлж болох. Тиймээс өмнөд хөршөөс эдийн засаг нь хамааралтай орнуудын өсөлт ойрын жилүүдэд суларч мэдэхээр байгааг Олон Улсын Валютын сан болон Дэлхийн банкнаас сануулж буй. Гэхдээ өсөлт саарсан ч Хятадын орон зай байсаар. Тус улсын аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл энэ онд нэмэгдэнэ гэх таамаглалыг өөрсдөө дэвшүүлж буй тул богино хугацааны нөхцөл байдал нааштай эргэж мэдэх нь ээ.

Ирэх онд эдийн засгийн өсөлтөө 7.7 хувьтай байхаар төсөөлж байгаа ч Хятадын эдийн засгийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой эрсдэл тулгарсан хэвээр. Ялангуяа бүс нутгийн хөрөнгө оруулалт буурсан нь ▶

▶ дуудаа биз ээ. Түүнчлэн халаагаа авсан Хятадын шинэ удирдагч бүтцийн өөрчлөлтөд анхаарах болсон нь ийн цухас илэрлээ. Дэлхий дээрх хамгийн хямд ажиллах хүч Хятадад байдаг. Тэгвэл ирэх жилүүдэд Хятад хүний хөдөлмөрийн үнэлэмж эдийн засгийн бүтцээ дагаад “зэрэг нэмэх” бололтой.

## “Дэлхийн үйлдвэрлэгч”-ээс “Дэлхийн хэрэглэгч” рүү

Хятад сүүлийн 30 жилийн турш ёс юм шиг хэрэгжүүлж байсан “Хямд ажиллах хүчний-экспорт”-д суурилсан эдийн засгийн загвараас татгалзлаа. Тэдний шинэ бодлогын жанжин шугам нь Хятадыг “Дэлхийн үйлдвэрлэгч”-ээс “дэлхийн хэрэглэгч” болгоход чиглэв. Цаашилбал инновацид суурилсан шинжлэх ухаан, технологийн хүчин чадлыг

дээшлүүлэх, боловсролыг хөгжүүлэх, ард түмний амьжиргаа, цалин хөлсийг нэмэгдүүлэхэд бодлогоо хандуулахаар завдлаа. Дян Сяопиний “Зарим нь ч гэсэн баяжих боломж олгох” бодлого түүх болж, 2005 онд Ху Зиньтао, Вэнь Зябо нар шинэчилж байсан “Чинээлэг нийгмийг бүтээн байгуулах” хөтөлбөр “хаалтаа” хийв. Хятадын эдийн засаг, экспорт нь дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, “тооноос чанарт шилжихэд” чиглэж байна.

Гадаад худалдаа Хятадын ДНБ-ий 25 орчим хувийг эзэлдэг бөгөөд үйлдвэрлэлийн индекс уруудсаар. Түүнчлэн сүүлийн жилүүдэд Хятадад хөрөнгө оруулалт буурч, үл хөдлөх хөрөнгийн “хөөс хагарсан” нь үйлдвэрлэл саарах гол шалтгаан болжээ. Гэсэн ч Хятадын өсөлт Засгийн газраас нь энэ онд тавьж буй 7.5 хувийн зорилтод хүрэх төлөвтэй байгааг Дэлхийн банкнаас мэдэгдсэн юм.

► Хятад руу үйлдвэрлэлийн хэрэгсэл, аж үйлдвэрийн түүхий эд нийлүүлэгч орнуудад сөргөөр нөлөөлөх магадлал өндөр байгаа аж.

## Өсөлт юу ч биш

Хурдаа хассан Хятадын эдийн засаг таамаглаж буй өсөлтөөсөө даруй 0.8 хувиар бага байх таамаг бий. Хятадын Засгийн газраас бүтээмж ба инноваци, хөрөнгө оруулалт бус хэрэглээнд дөрөөлсөн өсөлт бий болгох замаар эрэлтийг тэнцвэржүүлэхэд түлхүү анхаарч байгаа тул тус улсын өсөлт дунд хугацаандаа 7.5-7.7 хувийн хооронд хэлбэлзэх төлөвтэй байгааг Дэлхийн банкны бүс нутгийн тоймд тэмдэглэсэн байна.

БНХАУ эдийн засгийн өсөлтөө хадгалах үүднээс дотоодын хөрөнгө оруулалтаа сүүлийн жилүүдэд эрс нэмэгдүүлсэн. Тухайлбал, 2010 онд ДНБ-ий өсөлтөө 10.4 хувьд хүргэж чадсан юм. Харамсалтай нь 2011 онд үл хөдлөх хөрөнгийн үнэ унаснаар Хятадын эдийн засгийн өсөлт дахин саараад байгаа нь энэ. АНУ-ын эдийн засагтай хөтөлгөөтэй мэт Хятадын өсөлт ирэх жилүүдэд оршин тогтнохын тулд дотоод хэрэглээгээ тэлсэн бодлого хэрэгжүүлэхээр бүс нутгаа шавдуулахын зэрэгцээ сандаргаж магадгүй нь.

Хятадын эдийн засагт өрхийн хадгаламж онцгой үүрэгтэй. 2010 оны байдлаар нийт хадгаламжийн хэмжээ ДНБ-ий 53.9 хувьд хүрсэн байдаг. Нээлттэй бодлого хэрэгжүүлсэн эхний жилүүдэд дотоодын хэрэглээ Хятадын ДНБ-ий 50-52 хувийг эзэлсэн ч түүнээс хойших 20 гаруй жилийн туршид хэрэглээ хурдан өссөн ч эдийн засгийн өсөлт шиг хурдан байж чадаагүй. Үр дүнд нь 1990 –ээд оноос хойш ДНБ-д хувийн хэрэглээний эзлэх жин эрс буурч, ДНБ-ий 43-48 хувийг бүрдүүлэх болжээ. 2000 оноос ДНБ-ий өсөлт болон хэрэглээний өсөлтийн зөрүү улам холдож, 2009 онд өрхийн хэрэглээ ДНБ-ий дөнгөж 35.1 хувийг эзэлсэн байна. Эл байдал нь дотоодын эрэлтэд тулгуурласан эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх суурь шалтгааны нэг гэж

шинжээчид үзэж буй.

## Хуучны арга ард хоцорлоо

Улс төрийн шинэчлэл бүрэн дууссан ч эдийн засгийн шинэчлэл өрнөн буй Хятадад өнгөрсөн хугацаанд иргэдийнх нь амьжиргааны түвшинд дорвитой ахиц гарсангүй. Нөгөө талаасаа орлогын ялгаа үүсч, нийгмийн тэнцвэрт байдал алдагдах болсон нь шинэ удирдлагын санааг зовоох болжээ. Дэлхийн банкнаас гаргасан “Хятад-2030” тайланд “БНХАУ бүтцийн шинэчлэл хийж, Засгийн газрын үүрэг ролийг дахин тодорхойлж, төрийн өмчит компани, банкны бүтцийг шинэчлэн, хувийн хэвшлийг хөгжүүлэх шаардлагатай” талаар онцлон тэмдэглэжээ.

Одоогийн байдлаар Хятадад Төрийн өмчит компани /ТӨК/ болон төрийн оролцоотой үйлдвэр, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн ДНБ-

ий 40 хувийг эзэлж байна. “Хэрвээ төрөөс шууд удирддаггүй, ТӨК-ийн охин компаниуд, хөдөө орон нутгийн үйлдвэрүүд, улсын хөрөнгө оруулалт бүхий компаниудыг оруулан тооцвол ДНБ-ий даруй 50 орчим хувийг эзэлнэ. Эдгээр төрийн өмчит үйлдвэр нь Засгийн газраас хөнгөлөлт урамшуулал эдэлдэг тул зах зээл дээр тэнцвэр алдагдаж, хувийн компаниуд, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудаас давуу тал олж, өрсөлдөөний тэгш бус байдал үүсч байна” гэж Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэнгийн “Ху Зинтао, Вэнь Зябао нарын өвлүүлж буй Хятад орон” судалгааны өгүүлэлд дурджээ. Хямд ажиллах хүчинд дулдуйдсан Хятад илүү сайныг, илүү чанартайг хийхийг эрмэлзэх боллоо. Өсөлт саарсан ч эдийн засгаа дархлаажуулахаар Хятад бүтцээ “тодотгож” байна. ■

## БИЧИЛ САНХҮҮ

# БОСГО ДАВАХЫН ЗОВЛОН

## ЭЗОРИГТ

**Х**эзээ ч моодноос гардаггүй бас хэзээ ч моод болтлоо хөгждөггүй жижиг, дунд үйлдвэрлэл /ЖДҮ/ гэх эдийн засгийн чухал салбар Монголын үе үеийн Засгийн газрын шүдний өвчин гэхэд хилсдэхгүй. Иргэдийг ажлын байраар хангах, өрхийн бизнесийг дэмжих, дотооддоо үйлдвэрлэгч болох мөрөөдлийг биелүүлэхээр

Засгийн газар ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлийг тэрбум тэрбумаар нь гаргадаг. Гэтэл ЖДҮ эрхлэгчдийн зүгээс “Нөгөө хөнгөлөлттэй зээл чинь хаана байна аа. Бидэнд олдохгүй байна” гэх гомдол тасардаггүй. Өнгөрсөн сард болсон “Компанийн захирлуудын дээд хэмжээний уулзалт”-ын үеэр Монголбанкны ерөнхийлөгчөөс “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг Чингис бондоос хөнгөлөлттэй ►►

зээлээр санхүүжүүлж байгаа гэж худлаа яриад байх юм. Энэ зээл огт ирээгүй байгаа. Мөнгийг бидэнд хэзээ өгөх юм бэ” гэх асуултад ЖДҮ эрхлэгчид хариу нэхсэн нь үүнийг батална. Энэ мэт жинхэнэ эзэддээ хүрч чаддаггүй өөр олон зээлийг дурдаж болно. Тухайлбал, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сангийн гээд нэлээд хэдэн хөнгөлөлттэй зээл байдаг ч эргэлтийн хөрөнгөөр зээл авъя гэхээр олдохгүй юм гэсэн гомдол иргэдийн зүгээс гарсаар л байна. Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны гүйцэтгэх захирал Э.Ариунтөгс “ЖДҮ эрхлэгчдэд очих ёстой хөнгөлөлттэй зээл дунд шатандаа буюу банкинд очоод түгжигдчихдэг. Яагаад гэж та гайхаж магадгүй юм. Учир нь банк ЖДҮ эрхлэгчдэд зээл өгөхийн тулд зээлийн барьцаа хөрөнгө, ажилласан жил гээд олон шалгуур тавьдаг. Гэтэл гарааны бизнес эхлүүлэх гэж байгаа үйлдвэрлэгчид тэр шалгуурт нь тэнцдэггүй. Харин банкны өндөр шалгуурыг хангадаг хэсэг нь хэдэн

тэрбумаар тоологдох хөрөнгөтэй том компаниуд л байдаг” гэв. ЖДҮ дэмжих зээл том компаниудад очдог гэх гомдлын хариулт нь энэ байж болох юм. Харин бизнесийн шинэ санаатай нөгөө зорилтот хэсэг нь төрийн хөнгөлөлттэй зээлийг дээлээ гандтал хөөцөлдөөд ч олж чаддаггүй гэх. Тэгвэл энэ асуудлыг хэрхэн шийдэх вэ. Хариулт нь маш энгийн. Олон улсын жишгээр энэ төрлийн зээлийг банкиар биш Банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/-аар дамжуулан олгодог механизмыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэдгийг хэлэх хүн олон. Гэвч банк бус санхүүгийн байгууллага гэх нэрийг дуулахаараа ихэнх монгол хүний толгойд Хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/-дын дампуурал зурсхийдэг нь нууц биш. Гэтэл ХЗХ, ББСБ гэдэг нь санхүүгийн зах зээлийн тус тусдаа хэсэг юм. Хөдөлмөрийн яамны ЖДҮ-ийн хөгжлийн газрын дарга Б.Бат-Амгалан “Хүмүүс ББСБ гэхээр л ХЗХ шиг дампуурна гэж болгоомжилдог. Гэтэл Монголын банк бус санхүүгийн байгууллагууд 150 тэрбум төгрөгийн дүрмийн сантай. Одоогийн байдлаар нэг нь ч дампуураагүй. Банк бус санхүүгийн байгууллагууд өөрсдийнхөө найдвартай байдал, хөрөнгийн чадавхын талаар иргэдийн итгэлийг

төрүүлэхүйц танилцуулгыг хийж, сурталчилгаагаа зөв явуулах цаг нь болсон” гэв. Тиймээс ЖДҮ-ийг дэмжих болон бусад төрлийн хөнгөлөлттэй зээлийг ББСБ-аар дамжуулах давуу талын талаар тайлбарлахаас өмнө ББСБ, ХЗХ хоёрын ялгааг өгүүлэх нь зүйтэй болов уу.

## Ялгаа

Монгол Улсад зээлийн үйл ажиллагаа явуулдаг Банк, ХЗХ, ББСБ гэх гурван том субъект бий. Гурвуулаа өөр өөрийн гэсэн хуультай, өөрийн гэсэн онцлогтой. Тухайлбал, ХЗХ нь өөрсдийн гишүүдээс мөнгөн хөрөнгө хуримтлуулаад тэр хуримтлалаа гишүүддээ эргэн зээлдэг тогтолцоо юм. Харин ББСБ бол өөр. Хувийн хөрөнгө оруулагчийн хөрөнгөнд суурилсан санхүүгийн төрөл бүрийн үйл ажиллагаа явуулахыг хэлдэг. Хуульд заасанчлан нийт хөрөнгийн 70 гаруй хувь нь хөрөнгө оруулагчийн өөрийн хөрөнгө байдаг. Харин банкны секторын 10 хувь нь л өөрийн хөрөнгө байдаг бөгөөд 90 орчим хувь нь иргэдийн буюу хадгаламж эзэмшигчдийн хөрөнгөөс бүрддэгээрээ ББСБ-аас асар том ялгаатай юм. Энэ ялгаа нь мөн салбаруудын санхүүгийн зах зээлд эрсдэл даах чадварыг илэрхийлэх нэг том үзүүлэлт болдог. Түүнчлэн ХЗХ гэдэг нь зөвхөн гишүүдийнхээ хүрээнд санхүүгийн үйлчилгээ ▶



Монголын банк бус санхүүгийн байгууллагууд 150 тэрбум төгрөгийн дүрмийн сантай

► үзүүлдэг бол ББСБ-ын харилцагчид нь бичил санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчид болох дэлгүүрийн эзэд, бүх төрлийн үйлчилгээ үзүүлэгчид, гар урчууд, ЖДҮ эрхлэгчид гээд илүү өргөн хүрээг хамардаг. Харин одоо үндсэн асуудалдаа эргэн оръё.

Аливаа санхүүгийн байгууллагын үйлчилгээ нь тухайн орны иргэдийн орлоготой нягт холбоотой. Хэдий чинээ орлого багатай байна төдий чинээ санхүүгийн үйлчилгээ олдохгүй, үнэ өндөр хүнд суртал ихтэй болдог. Тиймээс л ихэнх бичил бизнес эрхлэгчид банкны босгыг давж чадалгүй ББСБ-ын хаалгыг тогшдог. Банкны босгыг өндөр болгодог гол хүчин зүйл нь ажилласан жил, барьцаа хөрөнгө гэх шалгуур байдаг талаар дээр дурдсан. Гэтэл ЖДҮ эрхлэгчид банкны эдгээр шалгуурт бүдрэх нь олонтаа. Зээл анх удаа авч буй ямар ч зээлийн түүхгүй шинэхэн бизнес эрхлэгчид банкиудын хувьд өндөр эрсдэлтэй ангилалд орж, зээлийн хүү болон барьцааны шаардлага улам өндөр. Бага эрсдэлтэй буюу бизнес нь тогтсон, зах зээлд байр сууриа олсон, мөнгөн урсгал нь жигдэрсэн компаниуд зээлээ эргэн төлөх чадамж өндөр. Тийм компаниуд бага хүүтэй зээл хүсч, банкууд ч өгөхийг хичээдэг. Гэхдээ үүнд банкиудыг буруутгаад байж болохгүй юм. Хас банкны гүйцэтгэх захирал Д.Бат-Очир “Банкны хөрөнгийн 90 гаруй хувийг хадгаламж эзэмшигчдийн мөнгө эзэлдэг болохоор ямар ч эрсдэлтэй алхам хийж болохгүй” гэсэн юм. Тиймээс тэдэнд чанаргүй зээл өгөх эрх байхгүй. Харин ББСБ бол өөр. Тэд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 60 хувьд нь хүрч үйлчилдэг. 390 мянган харилцагчтай. Тиймээс ЖДҮ эрхлэгчид хэн байдгийг тэд мэднэ. Түүнчлэн 320 гаруй тэрбум төгрөг ББСБ-иудын санд эргэж байна. Үүний 70 гаруй хувь нь банк бус байгууллагуудын өөрийнх нь хөрөнгө. Тиймээс тэд эрсдэл даах чадвартай. Тэр ч утгаараа зээлийн шалгуур өндөр биш, бичиг цаасны ажил бага байдаг. Ийм тогтвортой санхүүгийн салбарыг бид яагаад ашиглаж болохгүй гэж. “Бид” ББСБ-ын ерөнхий захирал А.Алтансүх “Банк

бус санхүүгийн байгууллагууд нийт хөрөнгийн хэмжээгээрээ банкны салбарын хоёр хувийг эзэлдэг ч өөрийн хөрөнгийн хэмжээгээрээ 20 орчим хувийг, үүн дотроо дүрмийн сангийн хэмжээ нь 45 хувийг эзэлж байна. Энэ бол бага тоо биш. Өөрөөр хэлбэл, банкны салбарыг бодвол банк бус санхүүгийн байгууллагууд нь харьцангуй эздийн өмчид тулгуурласан эрсдэлээ хариуцах тодорхой эзэнтэй байдаг. Энэ ч утгаараа үйл ажиллагааны болоод харилцагчид хүргэх эрсдэл гэсэн ойлголтоос хол” гэсэн юм. Тиймээс банкиуд эрсдэл багатай томоохон компаниудад зээлээ өгдөгөөрөө өгөөд, том компаниудад үзүүлсэн үйлчилгээнийхээ хөлсийг аваад яваад байж болно. Харин бичил бизнест чиглэсэн хөнгөлөлттэй зээлийг ББСБ-иар дамжуулах нь жинхэнэ эзэддээ хүрэх боломж юм. Ер нь гаднын орнуудад ийм л байдаг.

## Өөр нэг давуу тал

1993 онд санхүүгийн салбарын 93 хувийг банк эзэлдэг байсан бол одоо 96 хувь болчихсон байна. Энэ нь санхүүгийн салбарт банк хэтэрхий томорч бусад нь шахагдаж байгаагийн илрэл. Гэхдээ энэ нь санхүүгийн салбарын бусад хэсгүүд өөрсдөө хүчгүй болохоор Монголын зах зээлээс шахагдаад байгаа хэрэг биш. Харин манай төрийн бодлоготой шууд холбоотой гэдгийг хэлэх хүн олон бий. Учир нь дээр дурдсанчлан бүх л төсөл хөтөлбөр банкны сектороор дамжин хэрэгжиж байна. Үүний сөрөг тал нь Монголын эдийн засаг банк гэх ганцхан салбараас шууд хамааралтай болчихож байгаа юм. Аливаа салбарт ганцхан тоглогч монополь байх нь олон талын хор уршигтай. Адаглаад эдийн засгийн ухаанд өрсөлдөгч олон байвал хэрэглэгчид хождог гэх зарчим алдагдахад хүрнэ. Өнөөдөр Монголын банкны зээлийн хүү буурахгүй, санхүүгийн бүтээгдэхүүний үнэ өртөг өндөр байгаа нь үүнтэй ч холбоотой байж болох юм.

Бичил санхүүгийн байгууллага олон байх нь санхүүгийн үйл

ажиллагаа хүртээмжтэй болж, зээлийн хүү буурч, зээл авах боломж илүү өргөн цар хүрээг хамарна гэж Санхүүгийн зохицуулах хорооны Бичил санхүүгийн газрын дарга Н.Оюунчимэг тайлбарлаж байсан. Монголын арилжааны банкуудын зээлийн хүү нэг оронтой болохыг хүлээсээр 20 гаруй жилийн нүүрийг үзлээ. Зээлийн өндөр хүү төлөхийн зэрэгцээ, бизнесээ өргөтгөх боломж хомс. Тиймээс банкны зээлийн өндөр шалгуурыг давж хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадаагүй жижиг үйлдвэрлэгчид мунгинаж явсаар хөнгөлөлттэй зээлээс хоцорчихдог. Хөнгөлөлттэй зээл авч чадаагүй зарим нь бадар барин байж банкнаас өндөр хүүтэй зээл аваад хэдхэн сарын дараа өрийн дарамтад орж эхэлдэг. Гэтэл банкны “дотны анд” болсон томоохон компаниуд хөнгөлөлттэй зээлийн сургаар нь очоод бүх зээлийг нь хуу хамчихаад үйл ажиллагаа нь тэлсээр, эрх мэдэл нь данхайсаар. “Бид” ББСБ-ын ерөнхий захирал А.Алтансүх “Хэрвээ байдал энэ чигээрээ үргэлжлээд байвал Монголын санхүүгийн салбарын 99 хувийг банкны салбар эзэлж бусад нь санхүүгийн зах зээлээс арчигдана. Том үйлдвэрлэгчид нь банкнаас зээлээ авч үйл ажиллагаагаа өргөжүүлсээр ЖДҮ эрхлэгчдийг зах зээлээс шахна. Тэгээд үйлдвэрлэлийн салбарыг одоогийн томоохон компаниуд эзэлж, санхүүгийн салбарт банк монополь болно. Энэ үед бүтээгдэхүүний чанар муудаж, үнэ өртөг өндөр болно. Учир нь зах зээлд ямар ч өрсөлдөгч байхгүй болчихож байгаа юм чинь монголчууд тэр хувь заяатайгаа эвлэрэхээс өөр аргагүй болно” гэв.

Төр засгаас Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг баталж, санхүүгийн салбарыг хөгжүүлэх том алхмыг хийсэн. Гэхдээ энэ нь том үйлдвэрлэгчдэд очих санхүүгийн хөшүүрэг бий болгох арга. Харин одоо бичил бизнесээ дэмжиж, ядуурлыг бууруулах мөрөөдлөө биелүүлэхийн тулд ББСБ-уудыг дэмжиж “булчин суулгах” хэрэгтэй байна. Ингэж чадвал манай эдийн засаг тогтворжиж, ЖДҮ эрхлэгчид гоё мөрөөдөлтэйгээ хоосон үлддэг байдал ард хоцорч болох юм. ■

## ТООН МЭДЭЭ

Эдийн засгийн өнөөгийн эрүүл мэндийг тааруухан байгаа хямарлын дохио хэдийнэ ажиглагдаж эхэлсэн гэх нэг хэсэг байхад харин ч байж болох муу нөхцөлөөс харьцангуй эрсдэл багатай гарлаа гэх нөгөө тал бий. Тиймээс эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүдийг сүүлийн гурван жилийн байдлаар харьцуулсан графикийг хүргэж байна.

### Эдийн засгийн бодит өсөлт


Эдийн засгийн бодит өсөлт 2013 оны эхний хагаст 11.3 хувь байгаа нь өнгөрсөн гурван жилийн дундажтай ойролцоо түвшинд байна



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

### M2 мөнгөний нийтүүлэлтийн өсөлт


Нийт M2 мөнгө 2013 оны наймдугаар сарын эцсийн байдлаар жилийн 20 хувийн өсөлттэй байгаа нь өнгөрсөн гурван жилийн дундажас гурав дахин бага өсөлттэй байна



Эх сурвалж: Монголбанк

### Банкны зээлийн жилийн өсөлт


Банкуудын олгосон зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлт 2013 оны наймдугаар сарын байдлаар 46 хувь байгаа нь өнгөрсөн гурван жилийн дундажтай ойролцоо түвшинд байна



Эх сурвалж: Монголбанк

### Банкуудын төлбөрийн чадвар

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 2013 оны эхний хагаст 15.9 хувьд хүрч өнгөрсөн гурван жилийн дундажас 3.1 нэгж хувиар сайжирчээ



Эх сурвалж: Монголбанк

### Орон сууцны ипотекийн зээлдэгчдийн тоо

Орон сууцны ипотекийн зээлдэгчдийн тоо 40.6 мянгад хүрч, гурван сарын дотор 26 хувиар өслөө.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

### Өргөн хэрэглээний бараа тээвэрлэх хугацаа (хоногоор)

Өргөн хэрэглээний бараа тээвэрлэх хугацаа өнгөрсөн гурван жилийн дундажас долоо дахин хурдасчээ



Эх сурвалж: ЗТЯ

ЗОЧИН

# ОЮУТОЛГОЙ БОЛ ШАЛГАЛТ



Д.БЭХБАЯР

**Ж**ан-Себастьян Жак “Рио Тинто” компанийн Зэсийн группийн гүйцэтгэх ерөнхий захирлаар 2013 оны хоёрдугаар сараас эхлэн ажиллаж байгаа. 2011 онд “Рио Тинто”-гийн олон улсын үйл ажиллагаа хариуцсан ерөнхийлөгчөөр ажиллаж тус компанийн Өмнөд Африк, Австрали, Америк, Индониз дэх уурхайнуудын удирдлагын багийг чиглүүлэн ажиллаж байсан. Тэрбээр уул уурхайн, тэр дундаа хөнгөн цагаан, боксит, төмөрлөгийн салбарт стратеги төлөвлөлт, үйл ажиллагаа удирдлагын чиглэлээр 15 жилийн туршлага хуримтлуулсан. “Рио Тинто”-д орохын өмнө Тата Стил группын Удирдлагын багийн гишүүн, Стратеги төлөвлөлтийн багийг удирдан ажиллаж байв.

“Mongolian Ecomony” сэтгүүлийн сурвалжлах баг өнгөрсөн долдугаар сард Англи улсад хийсэн сурвалжлагынхаа үеэр “Рио Тинто” компаниар зочилж, түүнтэй ярилцсан юм. Лондонд байрлах “Рио Тинто”-гийн төв оффист ороход үүдний ханан дээрх видеогоор манай Өмнийн говийн зураг, Оюутолгойн барилга байгууламж, ажилтнуудын тухай мэдээлэл гарч байгаа нь нүдэнд тусав. Өөр нэг зүйл нь Монголын алт, зэсийн дээжийн билгэдэл болсон Лондонгийн Олимпийн медалийг шилэн хоргонд хийж үүдэндээ залжээ. Монголын үнэр шингэсэн эдгээр зүйлсийн дэргэд зураг авахуулах зуур нүдэндээ ▶

Фотог: Э.Зоригт

“Рио Тинто” компанийн Зэсийн группийн гүйцэтгэх ерөнхий захирал

► **инээмсэглэл** *тодруулсан монгол эмэгтэй ирж, бидэнтэй мэндчиллээ. Тэрбээр тус компанид корпорацийн харилцаа холбоо, брэнд хариуцсан мэргэжилтнээр ажилладаг ажээ. Ингээд Рио Тинто дахь монгол мэргэжилтэн Б.Энх-Ундрамын хамт Жан-Себастьян Жактай “Рио Тинто”-гийн хурлын танхимд ярилцсан юм.*

**-Юуны түрүүнд Монголын сэтгүүлчдийг хүлээн авч уулзаж байгаад талархлаа илэрхийлье. Та манай оронд хэдэнтээ очсон гэсэн. Хамгийн сүүлд хэзээ Монголыг зорьсон бэ?**

-Хамгийн сүүлд зэсийн баяжмалыг экспортлох ёслолын арга хэмжээний үеэр Монголд очсон. Бүх талын хувьд сэтгэл ихэд хөдөлсөн сайхан мөч байлаа. Нөгөө талаас Монголын Засгийн газрын төлөөлөл болсон зочид үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн. Тэдний хувьд ч маш чухал ач холбогдол бүхий үйл явдал байсан болов уу. Төслийн багийнханд зургаан тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт, 12 жилийн уйгагүй хөдөлмөрийнхөө үр шимийг үзэж эхлэх нь ямар сэтгэл хөдлөм байсан нь илт. Төсөл дардан замаар өдий хүрээгүй. Багагүй саад бартаатай тулсан учраас хүмүүс хийж бүтээсэн зүйлсээрээ бахархаж байлаа.

**-Одоогийн нөхцөл байдлыг дүгнээд харвал Монголын эдийн засаг урт хугацаанд ямар дүр төрхтэй харагдаж байна вэ?**

-Ашигт малтмалын арвин их нөөцтэй Монгол орны эдийн засгийн ирээдүйг сайнаар төсөөлж байна. Уурхайг асар их бүтээн байгуулалтын үндсэн дээр барьж байгуулдаг. Бид уурхайд ажиллаж буй нийт ажиллах хүчний 90 хувь нь монголчуудаас бүрдэнэ гэсэн хүлээсэн амлалтдаа хүрэхээр ажиллаж байна. Ер нь цаашдаа бид Монгол хэмээх агуулгыг нэмэгдүүлэх болно. Компани хүчтэй, чадварлаг ханган нийлүүлэгчидтэй байхыг хүсч байгаа. Мөн Монголын Засгийн газартай цахилгаан станц, сайн дэд бүтэц хэрэгтэй гэсэн асуудлууд дээр санал нэгдсэн. Манай зүгээс Оюутолгой Монголын эдийн засагт урт удаан хугацаанд

шууд болоод шууд бус байдлаар үр өгөөжийг үзүүлнэ гэдэгт илгэлтэй байдаг.

**-Энэ жил “Рио Тинто” үүсэн байгуулагдсаны 140 жилийн ой тохиож буй. Танай компанийг чухам ямар хүчин зүйлс дэлхийн хэмжээнд авчирдаг вэ?**

-Манай компани 140 гаруй жилийн турш үйл ажиллагаагаа явуулж байгаа. Энэ хугацаанд асар их туршлага хуримтлуулжээ. Бид ашигт малтмалын нөөцийг илрүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг осол аюулгүйгээр, үр ашгийг нь нэмэгдүүлэн ажилладаг. Энэ нь тийм ч хялбар зүйл биш. Мөн манай группын баримталдаг зарчим тодорхой. Энэхүү зарчмыг мөрдөж ажилласнаар урт удаан хугацаанд тууштай үйл ажиллагаа явуулж чадна гэдэгтээ итгэлтэй байдаг.

**-Компанийг чиглүүлэгч гол бодлого, зорилго юу вэ?**

-Бүх л компанийн адилаар хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтаас хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой ажилладаг. Бусдаас ялгарах манай онцлог гэвэл бид салбартаа хамгийн үнэ цэнэтэйд тооцогдох томоохон хэмжээний, зардлын хувьд өрсөлдөхүйц, урт хугацаанд ашиглагдах, өсөн нэмэгдэх нөөц бололцоо бүхий төслүүдэд хөрөнгө оруулалт хийх замаар үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ нь манай компанийн стратегийн салшгүй нэг хэсэг. Тиймээс аливаа хөрөнгө оруулалтын чанарт тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг.

**-Аюулгүй ажиллагаа уул уурхайн компаниудын хувьд хамгийн чухал. Рио Тинтогийн аюулгүйн зарчмууд гэж чухам ямар байдаг вэ?**

-Рио Тинто АНУ, Австрали, Монгол гээд дэлхийн аль ч оронд үйл ажиллагаа явуулсан аюулгүй ажиллагааны нэг л стандартыг дагаж мөрддөг. Бид аюулгүй ажиллагааг хангахын тулд дэлхийн өнцөг булан бүрээс мэргэжилтнүүдийг нэгтгэдэг. Оюутолгойн хувьд монгол мэргэжилтнүүдэд бодит туршлага хуримтлуулах үүднээс тэднийг Англи, Америк болон Австрали дахь Рио Тинтогийн уурхайнуудад ажиллуулж

байна. Ингэснээр тэд эргээд эх орондоо очихдоо Рио Тинтогийн аюулгүй ажиллагааны арга барилыг бүрэн хэрэгжүүлэх боломжтой болдог.

**-Оюутолгойн далд уурхайн үйл ажиллагаа тодорхой хэмжээний туршлага шаардана. Рио Тинто энэ тал дээр хэрхэн анхаарч байна вэ?**

-Бид шинээр сургууль төгсөгчдийн хөтөлбөрт цөөнгүй монгол залуучуудыг хамруулан туршлага хуримтлуулах зорилгоор Рио Тинтогийн томоохон уурхайнуудад ажиллуулж байгаа талаар ярьсан. Далд уурхайн үйл ажиллагааг таван жилийн өмнөөс эхэлсэн бөгөөд одоогоор хоёр босоо амыг барьж байгуулаад байна. Оюутолгойд мөн техник, мэргэжлийн сургалтын төвийг нээсэн. Энэхүү сургалтын төвийн симулятор машиныг ашиглан суралцагчид далд уурхайн орчинд ажиллаж байгаа юм шиг туршлага хуримтлуулах боломжтой. Ингэснээр ажилтнууддаа далд уурхайд ажиллахаас өмнө зохих технологиуд дээр аюулгүй орчинд дадлагдаж боломжийг нь бэлтгэж өгч байна.

**-Цөөн хүн амтай Монголд төдийгүй дэлхийд хүний нөөцийн асуудал том сорилт болж буй. Энэ бартааг даван туулах танай арга барил юу вэ?**

-Хүний нөөц, түүний хөгжих чадавхи бол хамгийн том сорилт. Тиймээс бид үүнд анхаарлаа хандуулж багагүй хөрөнгө оруулалт хийдэг. Оюутолгойд ажилладаг гаднынхан нэг л зорилгын төлөө тэнд байгаа. Тэд монгол боловсон хүчинд чадвар, туршлагыг зааж сургаж, өвлүүлж үлдээхээр ажиллаж байна. Гадны мэргэжилтэн бүр монгол ажилтныг дэргэдээ дагалдуулан сургаж, ажиллуулах зарчмаар туршлагыг шилжүүлж байна. Ингэснээр хэсэг хугацааны дараа монгол ажиллах хүч төслийг бие даан үргэлжлүүлэх боломжтой болно. Энэхүү зарчмыг Оюутолгой уурхайн бүх хэлтэст баримтлан ажиллаж байна.

**-Дэлхийн зах зээл дээр металлын үнэ хэлбэлзэлтэй байгаа энэ үед танай компанийн эрсдэлийн удирдлага хэрхэн хариу үзүүлэх бол? »**



Оюутолгой Монголын эдийн засагт томоохон хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна

► -Уул уурхайн салбарт өөрчлөлт мэдрэгдэж тус салбар нь сорилтот цаг үетэй тулгарч байна. Бүгд үндсэн хөрөнгөө эргэн тооцоолох, зардлыг дахин нарийн авч үзэх шаардлагатай тулгарч байна. Энэ бол том сорилт мөн бас шинэ боломж. Гэвч үүнийг зөвхөн зардал хөрөнгийн тухай асуудал гэж ойлгож болохгүй. Хэдэн тэрбум ам.доллар зарцуулан төсөл хэрэгжүүлж байхад хамгийн сайн баг ажлыг хийж гүйцэтгэж байгаа эсэхийг баталгаажуулах нь чухал. Тиймээс энэ нь зөвхөн хөрөнгө зардлын бус боловсон хүчний тухай асуудал мөн. Төсөл хэрэгжүүлэх үед зардлаас гадна тухайн төслийн үргэлжлэх хугацааг харгалзан үздэг. Үнэ ханш гэдэг байнга өөрчлөгдөж байдаг, түүнийг тогтоох боломжгүй. Энэ тохиолдолд бид хоёр хүчин зүйлсийг харгалзаж үздэг. Үүнд урт хугацаанд алс хэтээ харсан шийдвэрүүдийг гаргах, мөн аль ч тохиолдолд хувьцаа эзэмшигчиддээ хөрөнгө оруулалтаас хүртэх үр өгөөжийг нь нэмэгдүүлэхийг чухалчилдаг.

**-Иймэрхүү нөхцөлд компани зардлаа танах нь хямралын эсрэг авах эцсийн арга хэмжээ мөн үү?**

-Эцсийнх гэж хэлэх нь зохистой эсэхт итгэлтэй бус байна. Юм

бүхнийг бид олон талаас нь авч үздэг. Энэ бол асуудлыг ямар дараалалтай авч хэлэлцэх вэ гэдэгт оршдог болов уу. Зардлын хязгаарлалт нь өргөн цар хүрээтэй багц арга хэмжээнүүдийн зөвхөн нэг хэсэг нь.

**-Рио Тинтогийн хувьд хариуцлагатай уул уурхай гэж юу вэ?**

-Хамгийн чухал нь үйл ажиллагаа явуулсан газартаа эерэг нөлөөг үлдээх ёстой. Хариуцлагатай уул уурхай нь усны хэрэглээ, байгаль орчны удирдлага, орон нутгийн хөгжил гээд өргөн цар хүрээний асуудлуудыг хамардаг. Газар, газрын онцлогоос шалтгаалан хэрэгжүүлэх арга барил нь өөр хоорондоо ялгаатай байж болно. Гэхдээ гол нь тухайн орон нутагт эерэг нөлөө үзүүлэх ёстой гэдэгтээ итгэлтэй байх хэрэгтэй.

**-Дэлхийд тэргүүлсэн компани өнөөдрийн түвшинд улс орнуудад газар авч эхлээд байгаа "Resource Nationalism" буюу иргэдийн баялгаа өмчлөх гэсэн үндсэрхэг үзэлд хэрхэн хариу үйлдэл үзүүлж байна вэ?**

-Энэ бол зөвхөн Рио Тинтод бус бусад уул уурхайн компанид ч хамааралтай асуудал. Ерөнхийд

нь авч үзвэл, хөрөнгө мөнгө, боловсон хүчин бол хязгаарлагдмал. Тиймээс хамгийн боломжтой гэсэн төсөл, газар нутагт хөрөнгө мөнгийг зарцуулж боловсон хүчнийг ажиллуулдаг. Үүнийг мөн хүмүүс сайн ойлгох хэрэгтэй. Компани маань дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тогтвортой орчин, тууштай байдал маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү орчин хязгаарлагдмал тохиолдолд хөрөнгө оруулалт илүү тогтвортой орчин руу чиглэдэг. Хөрөнгө оруулагчдыг татах таатай орчин бол тогтвортой байдал. Зөвхөн уул уурхайн салбарын асуудал бус бусад бүхий л салбарт хамааралтай.

**-Рио Тинто компани хариуцлага биелүүлэх тал дээр хэрхэн ажилладаг вэ?**

-Рио Тинтогийн ажилтнуудын мөрдөж ажиллах бүхий л стандарт Монголд хэрэгжиж байна. Үндсэн нэг л төрлийн стандарт бий. Америкт, Монголд дэлхийн аль ч оронд үйл ажиллагаа явуулсан энэхүү стандарт жигд мөрдөгддөг. Бид ажиллагсдаа энэхүү стандартыг дагаж мөрдөхийг уриалдаг. Мөн бид улс төрийн үйл ажиллагаанаас ямагт ангид байх байр суурийг баримталдаг. Бүхий

л үйл ажиллагаа тогтсон дүрэм журамтай, тэдгээрийг байнга хянан шалгаж байдаг. Хянах шалгалтыг дотоод журмын дагуу, заримыг нь гуравдагч байгууллагын оролцоотой явуулж дэлхий даяарх үйл ажиллагаа дүрэм журмын дагуу тогтвортой явж байгааг ажиглаж ажилладаг юм.

**-Монголын хөгжил дэвшилд Рио Тинто ямар хувь нэмэр оруулна гэж та боддог вэ?**

-Олон улсын санхүүгийн корпорациас гаргасан статистик мэдээллүүдийг харвал Оюутолгой Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэлээд хэсгийг бүрдүүлнэ гэсэн мэдээллийг харж болно. Миний хувьд Оюутолгой Монголын эдийн засагт томоохон хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна. Оюутолгой амжилтад хүрэх нь чухал ач холбогдолтой. Оюутолгойн үйл ажиллагааг олон хүн анхааралтай

харж байна. Нэг ёсондоо Оюутолгой шалгалт мэт харагдаж байна. Хэрэв Оюутолгой шалгалтыг давж амжилт болж чадвал Монгол Улс цаашид илүү их хөрөнгө оруулалтыг татах боломж бүрдүүлнэ шүү дээ.

**-Монголын хууль эрхзүй, бизнесийн орчинд ямар давуу болон сул тал байна вэ?**

-Бид монгол ажиллах хүчнийг маш чадварлаг, сурах хүсэл эрмэлзэл өндөртэй гэж үздэг. Оюутолгойн амжилтын төлөө тэд шаргуу хөдөлмөрлөж байгаа нь илт харагддаг.

**-Монгол хүн анх удаа дэлхийн хэмжээний том компанийн удирдлагын багт ажиллаж байна. Б.Болдын Рио Тинтогийн Зэсийн группт ажиллаж буйг монголчууд олон талаас харж буй. Монгол хүнийг тус албан тушаалд ажиллуулсны давуу тал нь юу байх вэ?**

-Сэтгэл маш өндөр байгаа. Б.Болд миний өмнөх ажлыг хүлээж авсан. **Нэгдүгээрт**, Б.Болд өөрийн авьяас чадвараараа энэ түвшинд хүрсэн. **Хоёрдугаарт**, дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулахад шийдвэр гаргах түвшинд олон үндэстний бүрэлдэхүүн байх нь чухал. Тухайлбал, Өмнөд Африкт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол тухайн бүс нутгаас боловсон хүчинтэй байх нь чухал. Хамгийн гол учир нь тухайн газар нутагт зуу зуун жилээр үйл ажиллагаа явуулахад тухайн үндэстний соёл заншлыг ойлгодог байх нь нэн ач холбогдолтой. Соёлын зөрүүг арилгаж, сорилтыг давах шалгарсан арга бол тухайн үндэстний улсуудтай хамтарч ажиллах. Бид Монголын соёлыг ойлгохыг эрмэлзэж байгаагийн адил монголчууд ч Рио Тинтогийн соёлоос суралцаасай гэж хүсч байна.

**-Таны ажилд амжилт хүсье. ■**

2013.07.18

## АСУУДАЛ

# ХҮЛЭЭЛТ

### Б.АЛТАЙ

“Оюутолгой”-н хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах замаар энэ оны төсөвт 445.8 тэрбум төгрөгийг татах байсан. Гэвч хоёр тал тохиролцоонд хүрээгүйн улмаас улсын төсөвт 290.9, Хүний хөгжил санд 154.9 тэрбум төгрөгийн орлого тус тус дутах нь нэгэнт тодорхой боллоо. Тэгвэл ирэх оны төсөвт “Оюутолгой” компаниас нийт 161.5 тэрбум төгрөгийн татвар /ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр/ авахаар тусгажээ. “Оюутолгой” 723 мянган тонн зэсийн баяжмал, 24.9 тонн алт, 60.2 тонн мөнгө олборлож, дээрх орлогыг төсөвт бүрдүүлэх юм.

Харин энэ онд “Оюутолгой” компани 382 мянган тонн зэсийн баяжмал, 424 мянган унци алт, 802 мянган унци мөнгө үйлдвэрлэх байсан ч дээрх хэмжээнд хүрсэнгүй. Нөгөө талаасаа Монгол Улсад энэ онд орж

ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.6 тэрбум ам.доллараар буурч, нүүрсний үнэ унасан нь төсөвт тодотгол хийхэд хүргээд байна. Уг нь Монголын эдийн засаг энэ оны хагаст 11.3 хувиар өсөөд буй. Энэхүү өсөлтөд Оюутолгойн баяжуулах үйлдвэр ашиглалтад орж, зэсийн баяжмал экспортод гаргасан нь дам нөлөө үзүүлжээ. Оны сүүлийн хагаст Оюутолгойн экспорт жигдэрч, төслийн хүчин чадалдаа хүрснээр нийт дүнгээр 295 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх урьдчилсан тооцоо гарсан. Ингэснээр энэ оны эцэс гэхэд уул уурхайн салбар 20 гаруй хувиар өсөх таамгийг Сангийн яамнаас дэвшүүллээ.

### Ирээдүй ийм байна

Дэлхийн эдийн засгийн төлөв сайжрахгүй байгаагаас Хятадын эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлт удааширч, ▶



▸ эрдэс түүхий эдийн эрэлт, үнэд сөрөг нөлөө үзүүлсээр. Тухайлбал, энэ оны найман сарын байдлаар дэлхийн зах зээлд коксжих нүүрсний үнэ оны эхнээс 32, А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэсийн үнэ 14, төмрийн хүдрийн үнэ 17 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй гарчээ. Гэсэн ч ирээдүйд итгэх хангалттай шалтгаан бий. Хэдий гадаад худалдааны нөхцөл өнгөрсөн гурван жилийн дундажтай харьцуулахад 22 хувиар муудаж, экспортын эрэлт 10 хувиар буурсан ч горьдлого алдарсангүй. Учир нь уул уурхайн салбарт хэрэгжиж буй томоохон төслүүдийн үр дүнгээр ирэх онд манай улсын гадаад худалдааны бараа эргэлт 30 орчим хувиар өсч, 14 тэрбум ам.долларт хүрэх өөдрөг төсөөллийг Эдийн засгийн хөгжлийн яамнаас танилцууллаа. Тухайлбал, Оюутолгойн зэс, алтны ордоос нийтдээ 723.1 мянган тонн зэсийн баяжмал экспортлох аж.

## Асуудал эргэсэн үү

Лондон хотноо /2013.09.23-27/ болсон “Оюутолгой” компанийн хувь нийлүүлэгчдийн хурал Улаанбаатарт /2013.10.15-наас/ үргэлжилсээр. Хувь нийлүүлэгчдийн хоёр дахь шатны хэлэлцээ хэрхэх нь таамаг

төдий. Гэсэн ч харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, ээдрээтэй асуудалд цэг хатгах нь хоёр талын хүсэл. Мэдээж аль ч талд төслийг зогсоох, цаг алдах сонирхол үгүй. Удтал чилээсэн хэлэлцээрийн явцад улстөрийн оролцоог багасгах, судалгаа шинжилгээнд үндэслэсэн шийдвэр гаргах, гэрээний соёлд суралцах буюу нэг дүрмээр “тоглох” шаардлага байгааг хөрөнгө оруулагчдын зүгээс манайд илэрхийлсэн. Анхны хөрөнгө оруулалт тэлсэн, далд уурхайн хоёр дахь шатны санхүүжилт босгох, татвараа нэмэгдүүлэх гээд гэрээ хэрэгжих явцад үүссэн “үр дагавар” Монголын эдийн засагт таагүй нөлөө үзүүлсэн нь бий. Саар жишээнээс дурдвал өнөө жилийн буюу 11 дэх удаагийн “Discover Mongolia” хөрөнгө оруулалтын чуулга уулзалт түүхэндээ анх удаа маш цөөхөн оролцогчтой байсан. Түүнчлэн гацаанд ороод буй Оюутолгойн хувь нийлүүлэгчдийн үл ойлголцол сунжрах болсон нь хөрөнгө оруулагчдад эргэлзээ төрүүлсээр.

## Итгэлцэл

Оюутолгойн бүтээн байгуулалтыг түргэвчлэх хэд хэдэн шалтгаан бий. Учир нь 2018 он гэхэд дэлхийн зах

зээл дэх зэсийн үнэ одоогийнхоос буурах хандлагатайг шинжээчид таамаглаж, урьдчилан сануулж буй. Мөн Мозамбик, Чили, Афганистанд томоохон орд илэрч байгаа нь ирээдүйд зэсийн нийлүүлэлт нэмэгдсэнээр эрэлт хэрэгцээ үлэмж багасах эрсдэлийг дохиолсоор. Лондонд болсон хэлэлцээрт Монголын талаас 22 асуудлыг хөндсөн бол хөрөнгө оруулагч “Рио Тинто” талаас найман асуудлыг шийдвэрлэхээр оруулж ирсэн хэмээн “Оюутолгой” компанийн ТУЗ-ийн гишүүн Ч.Отгочулуу хэлсэн. Тэдгээрээс хоёр тал 15 асуудал дээр зарчмын хувьд тохиролцож, нэгдсэн ойлголтод хүрсэн. Харин Улаанбаатарт үргэлжилж буй хэлэлцээр үлдсэн 15 асуудлаар өрнөж байна. Ирэх өдрүүдэд “Оюутолгой”-н гэрээ тойрсон асуудал улам тодорхой болж, үл ойлголцол арилах юм. Төслийн нэмэлт санхүүжилтийн талаар ирэх арванхоёрдугаар сард хувь нийлүүлэгчдийн хамтарсан шийдвэр гарах бөгөөд үүнээс өмнө “нууц” 15 асуудлаар хоёр тал нэгдсэн ойлголцолд хүрэх аж.

## Мэдээллийн зөрүү

Хувь нийлүүлэгч талууд нэг завин дээр сууж яваа. Тиймээс завь хаашаа хазайна хөмрөх эрсдэл адилхан. Дэлхий нийтэд тархаж буй “Оюутолгой”-н талаарх мэдээлэл бодитой байх эсэхээс Монголын хөгжил шалтгаалж байгааг Ч.Отгочулуу хэллээ. Түүний өгүүлснээр “мэдээллийн сөрөг урсгал дөнгөж хөл дээрээ тэнцэж буй “Оюутолгой” компанийн “имиж”-ийг унагаж байгааг Лондонд илүүтэй мэдэрсэн” гэв. Лондон бол хил хязгааргүй санхүүгийн төв. Тиймээс Монголд “асч” буй улстөржилт, түүнээс үүдсэн “эх оронч” мэдэгдэл хөрөнгө оруулагчдад “сануулга” өгдөг байна. Нөгөөтэйгүүр “Оюутолгой” төсөл Монголд бусад хөрөнгө оруулалтыг араасаа дагуулж буй анхдагч түүчээ. Гэтэл мэдээллийн зөрүүнээс болж Монгол Улс алдагдал хүлээж байгааг ТУЗ-ийн шинэ гишүүн ажигласан байна. ■

## ОЮУТОЛГОЙ

# ХӨГЖЛИЙН УНАА ХӨДӨӨГ ЗОРЬЖЭЭ

Б.БАЯР

Ажилтай, орлоготой хэн бүхний амьдрал дэвжин цэцэглэж, хот хөдөөг эс ялган хөгжил түгсээр. Тухайлбал, Өмнөговь аймгийн Ханбогд сум сүүлийн жилүүдэд эрчимтэй өнгө засжээ. Иргэдийнх нь амьжиргааны түвшин мэдэгдэхүйц дээшилж, хязгаар сум гэхэд аймгийн төв гэлтэй хөл хөдөлгөөн нүргэлнэ. “Оюутолгой” компани ийнхүү орон нутгийн хөгжилд онцгой дэвшил авчирсан болохыг нутгийнхан сонин сайхан болгон өгүүлэх аж. Ханбогдчууд “Оюутолгой”-н уурхайд жолооч, агуулахын ажилтан, баяжуулалтын дээжлэгч, орон нутгийн харилцааны ажилтан, тоног төхөөрөмжийн оператор, бутлуур, карьерын механик, засварчин зэрэг олон төрлийн ажил эрхэлдэг юм байна. Тэдний нэг нь “Оюутолгой” компанийн Тээврийн хэлтсийн жолооч Д.Мөнхтөр. Тус компанид 2011 оноос жолоочоор ажиллаж байгаа бөгөөд Ханбогдын уугуул. Ажил, мэргэжлийн дөр сууж яваа түүний амьдралд бодитой өөрчлөлт гарч байгааг тэрбээр онцлоод цөөн үгэнд хөгжлийг багтаасан юм.

Дэлхийн хэмжээний “Оюутолгой” төсөлд ажиллана гэдэг нэр төрийн хэрэг бас бахархал. Тиймээс олон, олон монголчууд “Оюутолгой”-д ажиллах хүсэлтэй байдаг. Гэвч хэмжээтэй “сав” тул уг хүсэл хясал болох нь бий. Хамгийн гол нь уул уурхайн компанид ажиллахад



“Ханбогд, Манлай, Баян-Овоо сумын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц хөтөлбөр” хоёр жил дараалан хэрэгжиж байна

мэргэжил, мэдлэг, ур чадвар эхний асуудал. Өнөөдөр эдгээр шалтгаанаас болж ажиллах хүсэлтэй иргэд “Оюутолгой”-н гадна үлдэх бэрхшээлтэй нүүр тулаад байгаа. Тэмүүлэл байсан ч ажлын байрны шаардлага хангана гэдэг тэдэнд бэрх даваа болоод буй. Тиймээс “Оюутолгой” компанийн Хүний нөөц, сургалт болон Бүсийн хөгжил, нийгмийн хэлтэс хамтран ажил идэвхтэй хайж байгаа иргэдэд зориулан “Ханбогд, Манлай, Баян-Овоо сумын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц хөтөлбөр”-ийг үе шаттайгаар хоёр жил дараалан хэрэгжүүлж байгаа аж.

Орон нутгийн иргэдийн хувьд хотод ирээд сургалтад хамрагдах нь хомс. Түүнчлэн санхүүгийн бэрхшээл гардаг тул бүдрэх нь их.

Мөн шинэ төгсөгчид мэргэжлээрээ ажиллахад хэлний мэдлэг хангалтгүй, ур чадвар дутмаг зэрэг олон асуудал үүсэх учраас дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь цагаа олсон ажил болжээ. Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхээр “Оюутолгой” компаниас цөөнгүй ажлыг санаачлан хийж байгааг Ханбогдод очоод мэдлээ. Иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэх, ур чадварыг сайжруулах зорилготой хөтөлбөрийн эхний үе шат нь англи хэлний сургалт аж. Тус сургалт зургаан сарын турш үргэлжилсэн бөгөөд хичээлийн үр дүн гарч, суралцагчид англи хэлний сургалтаа амжилттай дүүргэсэн байна. “Хэлтэй бол хөлтэй” өнөө цагт гадаад хэлний мэдлэг гэдэг ажлын ▶▶

► анхны босго юм.

“Оюутолгой” компанийн Хүний нөөц бүрдүүлэлт хариуцсан ажилтан Е.Мэндмаа “Орон нутгийн иргэд хөтөлбөрт маш идэвхитэй хамрагдлаа. Насны хувьд харилцан адилгүй байсан ч ажил, хичээлээ зохицуулж суралтандаа хичээнгүйлэн суусан хүмүүс амжилттай төгссөн” гэв. Орон нутагт төдийлэн мэргэжлийн багш нар ирээд байх нь ховор. Тэр тусмаа үнэ төлбөргүй, эдийн засгийн хэмнэлттэй сургалт зургаан сар зохион байгуулах бараг л боломжгүй.

Е.Мэндмаа “Орон нутагт мэргэжлийн багш нар бүтэн зургаан сар сургалт явууллаа. Эрдмийг хичээлээр сурна гэдэг. Хувь хүн өөрөө л хөдөлмөрлөж байж амжилтанд хүрнэ. Бид цэцэг тарих хөрсийг нь бэлдэж үрийг нь суулгаж өгсөн. Харин услаж тордож ургуулах хэрэгтэй” хэмээсэн. Боломж байнга тохиодоггүй.

Зөвхөн Өмнөговьд англи хэлний “давлагаа” өрнүүлээд зогсохгүй “Оюутолгой” компани Хөдөлмөрийн төв биржтэй хамтран хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх зөвлөгөө, сургалтыг зохион явуулж, олон нийтэд шинэ мэдээлэл өгчээ. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц хөтөлбөр”-ийн дараагийн үе шат болох Мэргэжилтэй ажилтан бэлтгэх суурь сургалтын бэлтгэл ажлууд орон нутагт эхэлсэн байна. Дээрх хөтөлбөрт хамрагдаж, олон хүн ажлын байртай болсныг дээр өгүүлсэн. Тус сургалтаар дамжуулан ажилтай, орлоготой, мэдлэг, туршлагатай болсон хүмүүсийн нэг бол Г.Анхбаяр. Тэрбээр “Оюутолгой” компанийн Баяжуулалтын хэлтсийн Тосолгооны техникчээр ажиллаж байна.

Улаанбаатарт ажил, мэргэжил эзэмшихэд эхний ээлжинд хэтэвчээ хоослох нь энүүхэнд хэрэг. Дараа нь ажилтай болно гэдэг амаргүй. Хайж хүлээх нь ердийн үзэгдэл. Тэгвэл орон нутагт суралцах таатай орчин нөхцөл бүрдэж байгаагийн зэрэгцээ ажлын байр бэлээхэн байгаа нь дэвшил. Сурлаа, төгслөө, ажилд орлоо. Тиймээ, хөдөөд хөгжил байгааг эл байдал тод харуулна. ■

## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

# БУСДААС ЯЛГАР



И.ОТГОНЖАРГАЛ

**Компанийн нийгмийн хариуцлагыг монголчууд өөр өөрийнхөөрөө ойлгодог. Тэгвэл хувь хүн, компани, улс орны хөгжилд том дэм болох дээрх ойлголтыг Монголд зөв төлөвшүүлэн хөгжүүлэх чиглэлээр ГОУХАН/GIZ-гийн Эдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга төслөөс суулийн хоёр жилийн хугацаанд багагүй ажил хийж байгаа билээ. Тухайлбал, өнгөрсөн зургадугаар сард “Нормисур интернэйшнл” байгууллагын ерөнхийлөгч хатагтай Селина Паганиг урьж, “Оролцогч талуудын стратеги боловсруулах нь” сэдвийн хүрээнд Монголд компанийн нийгмийн хариуцлагын үндэсний сургагч багш нарыг анх удаа бэлдсэн юм. Хатагтай Селина**

**Паганигийн ярилцлагыг хүргэж байна.**

-Та Монголд компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ын тухай сургалтыг анх зохион байгууллаа. Таны бодлоор манай оронд КНХ чухам ямар түвшинд байна вэ?

-Энэ сургалт маш өвөрмөц болж өнгөрсөн гэж хэлж болно. Сургалтад хамрагдсан хүмүүсийн ихэнх нь компаниудын төлөөлөл байсан. Гэхдээ Засгийн газар, иргэний нийгэм болон хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулж чадсан. Өөр өөр салбараас хүмүүсийг нэг дор цуглуулж, сургалтад хамруулах нь ховорхон байдаг. Учир нь тэдний үзэл бодол ялгаатай байдаг оршино. Мэдлэгийн нийтлэг суурь үндсийг бий болгож чадсан гэж бодож байна.

Миний хувьд Монголын соёлын ►

▶ талаар олон зүйл сурч, ялангуяа бидний өдгөө яриад буй КНХ-ын асуудалд монголчууд хэрхэн хүндэтгэлтэй ханддаг байсан зан заншлыг олж мэдсэн. Монгол оронд өнгөрсөн 23 жилд маш том өөрчлөлт гарч, эдийн засаг нь огцом өсч, илүү их баялгийг бүтээх болсон. Олон өөрчлөлт гарсны дээр заримыг нь ч хойш тавьсаар ирсэн. Гэхдээ үүнд л гол үнэ цэнэ нь байсан гэж бодож байна. Энэ нь монголчуудын санаа бодол ирэх арван жилд тогтвортой хөгжилтэй болох чиглэл рүү эргэх болно гэсэн үг.

**-КНХ-ын талаар ярихаар оролцогч талуудын асуудал чухлаар хөндөгддөг. Монголд уул уурхайн салбар хурдацтай хөгжиж буй. Гэтэл оролцогч талууд болон уул уурхайн компани, төрийн байгууллага, орон нутгийн хооронд үл ойлголцол байсаар байна. Энэ оролцогч талуудын оролцоог хэрхэн хангах вэ?**

-Оролцогч талуудыг заавал оролцуулах ёстой гэсэн дарамт, шахалт уул уурхайн компаниудад ирдэг юм шиг санагддаг. Учир нь тэдгээр компанийн үйл ажиллагаатай нь холбоотой. Гэхдээ оролцогч талуудаас айж эмээлгүйгээр КНХ-ыг зүй зохистой хэрэгжүүлэх боломж байгаа. Оролцогч талууд хэтэрхий их асуултаар булдаг байж болох талтай. Компаниуд тойрон хүрээлж буй оролцогч талуудаа сайн ялгаж салгадаг байх хэрэгтэй бөгөөд оролцогч талууд нь тухайн компанийн нөлөөнд автсан эсхүл тэд тухайн компанид нөлөөлдөг ч байж болох юм. Тэгэхээр тэдний оролцоог хангахын тулд тодорхой стратеги, бодлого хэрэгтэй болно гэсэн үг. Гэхдээ ганцхан удаа хэрэглээд орхих биш. Тэдэнд итгэл төрүүлнэ гэдэг цаг хугацаа шаардсан ярвигтай ажил. Мөн тэвчээртэй хүлээж, шат шатаар хэрэгжүүлэх шаардлагатай болно. Хамгийн чухал нь тэдний итгэлийг олж авах. Энэ нь шууд хийчихдэг амар хялбар зүйл биш юм. Оролцогч талууд харилцан адилгүй байдаг. Заримдаа хүндрэлтэй тулгарах үе ч бий. Энэ нь КНХ-ын мэргэжилтнүүд дангаараа хийчих ажил ч бас биш бөгөөд тухайн компанийг бүхэлд нь

хамрах асуудал. Энэ бол томоохон төсөл гэж ойлгож болно. Монгол оронд КНХ-ын хөгжил эхлэл шатандаа явж байна. Уул уурхай зэрэг зарим салбарт энэ асуудлыг хөндөх хэрэгтэй байгаа бөгөөд хэрэндээ чармайж буй компаниуд ч бий. КНХ-ыг хэрэгжүүлэхдээ стратеги талаас нь илүү анхаарах нь зүйтэй болов уу.

**-Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид компанийн нийгмийн хариуцлагын ойлголттой болох нь маш чухал юм байна. Тэднийг энэ тал дээр хэрхэн хариуцлагатай болгох вэ?**

-Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн хувьд КНХ-ыг хэрэгжүүлэх боломжтой. Гэхдээ мэдээж өөр арга барилаар. Жижиг компани олон нийтэд их хэмжээний мөнгө, орлого оруулж чадахгүй нь ойлгомжтой. Харин зарим бараа бүтээгдэхүүнээрээ олон нийтийг хангах боломжтой. Гэхдээ тэд зардал ихтэй томоохон төсөл, хөтөлбөрийг ажилтнууддаа зориулан боловсруулах нь юу л бол. Үүнийг Засгийн газрын түвшинд авч үзэх хэрэгтэй байх. Жижиг, дунд бизнес эрхлэгчид өөрсдийн ханган нийлүүлэх сүлжээндээ КНХ-ыг хэрэгжүүлэх замаар дэмжлэг үзүүлэх боломжтой. Тиймээс жижиг компаниуд нөлөө үзүүлж чадна гэсэн үг. Засгийн газрын зүгээс жижиг компаниудын нөөц, чадавхыг бэхжүүлэхийн тулд цаашдаа зарим нэг сан байгуулж болох юм.

Би өөрийн туршлагаасаа хэлэхэд жижиг компаниуд маш богино хугацаанд өрсөлдөх чадвартай болохыг эрмэлздэг. КНХ өрсөлдөх чадварт нь эерэгээр нөлөөлөхийг олж харвал тэд үүнийг хэрэгжүүлдэг. Хэрэв шаардлагагүй гэж үзвэл КНХ нь зардал өндөртэй, өөрсдөд нь зориулагдсан бус, мөн том компанид л зориулсан гэх мэтээр хандах нь бий. Тиймээс зарим бэрхшээлтэй тулгардаг. Юуны түрүүнд ямар саад тулгараад буйг олж мэдэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, тэд энэ тухай юу гэж бодож байгаа талаар гэсэн үг. Тэдэнд зориулсан хэрэглэхэд хялбар арга хэрэгсэлтэй байх нь чухал. Гол нь хялбархан, амьдралд илүү ойрхон байх хэрэгтэй. Үүнийг ойлгохын тулд тэд бүхэл бүтэн долоо хоног

зориулахгүй нь ойлгомжтой. Аль болох цаг хэмнэсэн, шуурхай байх хэрэгтэй. Жижиг компаниуд богино хугацаанд ашиглах боломжтой арга хэрэгсэлд дуртай байдаг. Цаашид ийм боломж гарах байх гэж бодож байна. Цаашид Засгийн газар болон компаниудын хоорондох түншлэлээс цаашид туслалцаа, дэмжлэг үзүүлдэг болох байх гэж найдаж байна. Энэ асуудлыг тусгайлан сэдэв болгон авч үзэх нь зүйтэй. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан санаа, санаачилга хэрэгтэй болно. Ирээдүйд биелэлээ олно байх гэж бодож байна. Учир нь Монголын томоохон компаниуд харьцангуй эмх цэгцтэй болж эхэлж буй. Энэ бол эхний алхам юм.

**-КНХ-ыг хэрэгжүүлэх тал дээр компаниудыг хэрхэн дэмжих боломжтой вэ?**

-Компанид зориулсан хууль, дүрэм бий. Ямар ч шаардлага тавиад үл ойшоодог компани ч байдаг. Тэдэнд арга хэмжээ авахаас өөр аргагүй болно. Энэ тохиолдолд компаниуд КНХ-ын нэмүү өртгийг тооцож үздэг болох хэрэгтэй байх. Хэрэв тэд КНХ-ыг сайн хөрөнгө оруулалт гэж үзвэл хэрэгжүүлж эхэлдэг. Тиймээс би компанийн ТУЗ болон гүйцэтгэх захиралтай уулзаж, ярилцахыг боддог. Тэдний ажил, бизнест КНХ сайнаар нөлөөлнө гэдэг итгэл, үнэмшлийг төрүүлэх хэрэгтэй. Үүнийг бизнес эрхлэгчдэд ойлгуулах нь хэр чухал гэдгийг ухамсарлах шаардлагатай юм. Хэрэв нэгэнт ойлгуулсан бол цаашид стратеги гаргах нөөц, бололцоо байгаа эсэх, тухайлсан талбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж эхлэх эсэх зэрэг асуудал урган гарч ирнэ. Үүнийг боломжит нөөц, бололцоондоо тулгуурлан хийх нь зүйтэй.

Зарим бизнес эрхлэгчид КНХ-ыг хэрэгжүүлдэг шалтгаан нь ёс суртахууны асуудалтай холбоотой байдаг. Учир нь тэд КНХ-ыг хэрэгжүүлэх нь зөв зүйтэй зүйл хэмээн үздэг. Миний ойлгосноор хаа газрын бизнес эрхлэгчид адилхан бодолтой байдаг. Тэд ихэнхдээ КНХ өөрсдийнх нь бизнест хэр ашигтай вэ гэдэг талаас хардаг. Зарим компанийн хувьд өрсөлдөгчид нь КНХ- ▶

► ыг хэрэгжүүлээд байгаа учраас мөн хэрэгжүүлэхээс өөр аргагүй байдалд ордог байх. Энэ нь тэдгээрийн хооронд жижигхэн өрсөлдөөнийг үүсгэж буй хэрэг. Харин зарим нь “Би хоцрогдмооргүй байна шүү дээ. КНХ-ыг хэрэгжүүлэе” гэж хэлдэг.

КНХ нь заримдаа шагнал, урамшуулал хосолсон, мөн хөрөнгө оруулагчид эсхүл хэрэглэгчийн зүгээс ирэх дарамт, шахалт хосолсон хэлбэрээр байдаг. Монголын ард иргэд КНХ-ыг компаниудаас шаардах хэмжээнд хүрэх хараахан болоогүй байна. Гэхдээ ирэх таван жилд ийм зүйл болох нь тодорхой. Энэ тал дээр бүхэл бүтэн хөдөлгөөн ч өрнөх болно. Компаниудын хувьд өөр хэлбэрээр дарамт, шахалтыг мэдрэх болно. Үүнийг ойлгож, нэмүү өртгийг зарж боруулдаг болно. Хэрэв энэ чиглэлээр юу ч хийхгүй бол үйлдвэрийг нь хааж, зах зээлийн хувь хэмжээ, үйлчлүүлэгчдээ алдаж, мөн Засгийн газраас торгууль ногдуулах зэрэг арга хэмжээ авдаг болох юм. Янз бүрийн зөөлөн хэлбэрийн тэмцэл өрнөдөг болно. Үүний дүнд тэд сэрэх л болно.

**-КНХ-ыг хэрэгжүүлснээр компанид ямар ашигтай юм бэ?**

-КНХ-ыг бизнес хийх арга замтай адилтгаж болох юм. Хэрэв та компанитай бол КНХ-ыг хэрэгжүүлэх нь чухал юм. Учир нь үүнийг чухалчилдаг хэрэглэгчид цөөнгүй байдаг. Хэрэв КНХ-ыг хэрэгжүүлэхгүй бол бараа, бүтээгдэхүүнийг нь хэрэглэгчид авахгүй байх нь энүүхэнд. КНХ-ыг хэрэгжүүлснээр тухайн компани ирээдүйд бусдаас ялгарах онцлогтой болно. Тухайн компани байгаль орчныг тодорхой хэмжээгээр бохирдуулдаг байлаа гэхэд хэдийгээр бохирдлын хэмжээ нь холбогдох хууль, дүрэмд заасан дээд хэмжээнээс доогуур байж болох ч энэ нь олон нийтэд хор хохирол учруулсаар буй гэсэн үг. Цаашилбал олон нийт тухайн компанид гомдол гаргаж эхэлнэ. Энэ нь цаашдын бизнест нь нөлөөлөх болно. Харин КНХ бизнесийг улам өргөжүүлэн тэлэх боломжийг олгодог. КНХ нь илүү үр дүнтэй ажиллахад дэмжлэг болох бөгөөд иргэдийн дунд нэр хүндийг олоход тустай.

**-Засгийн газрын зүгээс энэ тал дээр хэрхэн анхаарвал зохистой вэ?**

-Засгийн газрын агентлаг КНХ-ыг хэрэгжүүлбэл компаниуд хүндэлж эхэлнэ. Мөн КНХ-ын тал дээр юу ч хийхгүй байгаа компаниудад хариуцлага тооцдог болно. Мэдээж тэдэнд таатай байхгүй нь ойлгомжтой.

Төрийн бус байгууллага (ТББ)-ын хувьд компаниуд болон Засгийн газартай түншлэх сонирхолтой байдаг. Хэрэв аль аль нь КНХ-ыг хэрэгжүүлдэг бол энэ нь түншлэлд сайнаар нөлөөлөх нь дамжиггүй. Түншлэхэд ч илүү хялбар байх болно. ТББ компаниудаас санхүүжилт авах боломж ч бүрдэх юм. Тэдний үйл ажиллагаа илүү үр

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ЗОЛИОСЛОХ ЁСГҮЙ



**Б.ЦОГТБААТАР**

*/Саймон Фрейзерийн их сургуулийн Эрүүл мэндийн шинжлэх ухааны сургуулийн докторант/*

Уул уурхайн салбар багагүй хугацаанд Монголын эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгүүр байх нь. Том боломж том эрсдэлийг дагуулдаг хойно, хөгжлийн энэ боломжтой хамт нийгэм, байгаль орчны хүчин зүйлүүд болон хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой хүний эрүүл мэндийн эрсдэлүүд тулгарах бодит

магадлал бий. Тиймээс учирч болох эрсдэлүүдийг урьдчилан харах, зайлсхийх, нөлөөллийг бууруулах үйл явц төслүүдийн үйл ажиллагааны үе шат бүрт түрүүлэн буюу зэрэгцэн явагдаж байх ёстой. Шийдвэр гаргагчид болон мэргэжлийнхэнд энэ боломжийг Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ(ЭМНҮ) олгож чадна. ►


▶ дүнтэй байх боломжтой.

**-Сүүлийн үед монголчууд КНХ, компанийн засаглал гэж их ярих боллоо. КНХ нь компанийн засаглалын нэг хэсэг үү, эсвэл хоёр өөр ойлголт уу. Ер нь ямар ялгаатай вэ?**

-Сайхан асуулт байна. Монголчуудын хувьд КНХ-ыг компанийн засаглалтай андуурах

тохиолдол байдаг. КНХ нь компанийн засаглалаас хавьгүй том, өргөн хүрээг хамарсан ойлголт юм. Компанийн засаглал нь КНХ-ын гол сэдвүүдийн нэг. Компанийн засаглалын хүрээнд тухайн компани хэрхэн шийдвэр гаргах, ёс суртахуунтай байгаа эсэх, ил тод байгаа эсэх эсхүл бизнесээ хэрхэн удирдан явуулж байна гэх мэт

асуудал хөндөгддөг. Тэгэхээр энэ нь нэг төрлийн элемент юм. Харин КНХ нь илүү том элемент бөгөөд үүнд ажилтнуудтайгаа хэрхэн харьцах, бараа, бүтээгдэхүүн хэр баталгаатай эсэх, олон нийттэй харилцах харилцаа ямар түвшинд байгаа, байгаль, орчныг бохирдуулж байгаа эсэх зэрэг олон чухал асуудлыг хамардаг. ■



## Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ гэж юу вэ?

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ/ЭМНУ/ бол “мэдээлэлжсэн шийдвэр гаргах үйл явц” бөгөөд үүнийг уул уурхайн төслийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, урьдчилан тогтоогдсон эрсдэлийг арилгах хөтөлбөр хэрэгжүүлснээр, иргэдийн эрүүл мэндэд эерэгээр нөлөөлөөд зогсохгүй тухайн төслийг тогтвортой, ашигтай байх боломжийг хангах ач холбогдолтой байдаг. Тус үнэлгээний хувьд одоогоор манай оронд Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ)-ний хавсарга байдлаар төлөвшиж эхэлж байна. Учир нь ЭМНУ-г бодвол БОНУ-ний хууль нь анх 1998 онд батлагдсан, тогтолцоо нь харьцангуй төлөвшсөн, хүмүүс нь туршлагажсан учраас Монголд ЭМНУ-г хөгжүүлэхээр зоригсдын

хувьд нэгэнт тогтсон энэ тогтолцоон дээр түшиглэн нэвтрүүлэх алхмууд хийгдэж байгаа. Энэ хүрээнд БОНУ-ний хуулийн шинэчилсэн найруулгад ЭМНУ-ний асуудлыг багтаах, холбогдох салбарын сайдуудын түвшинд хамтын ажиллагааны санамж бичиг үзэглэх, үнэлгээний аргачлалуудыг уялдуулах, албажуулах гэсэн ажлууд хийгдээд байна. Энэ хоёр үнэлгээний ерөнхий зарчим, аргачлалууд нь хоорондоо төстэй ч, гол нь эрсдэл болон нөлөөллийг нь тогтоогч объектоороо хоорондоо ялгагдана. Эрүүл мэндийн үүднээс авч үзвэл БОНУ-ний хувьд хүний амьдрах орчны үндсэн элементүүд болох хөрс, ус, агаарын бохирдол, чанарыг үнэлснээр хязгаарлагддаг байхад ЭМНУ нь хүний эрүүл мэндэд шууд болон шууд бусаар нөлөөлөх магадлалтай байгаль орчин, нийгмийн бүхий л хүчин зүйл болон хөдөлмөрийн аюулгүй байдал зэргийг цогцоор нь үнэлэхийг зорьдгоороо давуу

талтай. Аливаа хүн эрүүл амьдрах гэдэг нь өвчин эмгэггүй байгаад зогсохгүй биемахбодь, сэтгэлзүй, нийгэм, оюун санааны нэгдмэл эрүүл орчинд амьдарч өөрийн амьдралын зорилго, хэрэгцээгээ ухамсарлаж чаддаг, амьдралын орчиндоо дасан зохицох, өөрчлөх чадвартай байхыг хэлдэг. Хувь хүн, нийт хүн амын эрүүл мэндэд дангаараа буюу бусад хүчин зүйлүүдтэй хавсран нөлөөлж болох удамшлын, хувийн, нийгмийн болон ус, агаар, амьдарч буй орон байр, хоол хүнсний чанар, аюулгүй байдал гэх мэт хүрээлэн буй орчны бүхий л хүчин зүйлүүдийг нэгтгэн эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлүүд (ЭМТХЗ) гэж нэрлэдэг бөгөөд үүнийг ашиглан уул уурхайн аливаа төсөл, хөтөлбөр хүний эрүүл мэндэд үзүүлэх шууд бус нөлөөллийг үнэлж, хэмжинэ. Дэлхийн хэмжээнд ЭМНУ-г дөнгөж 1996 оноос ашиглаж эхэлсэн хэдий ч Шинэ Зеланд, Тайланд, Өмнөд Солонгос, Европын ▶

Холбоо зэрэг оронд хуульчилсан бөгөөд ЭМНҮ 100 хувь хийгддэг бол үндэснийхээ түвшинд хуульчлаагүй хэдий ч аргачлалаа сайжруулах, чадавхиа бэхжүүлэх, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зэргээр ЭМНҮ-ний дэмжлэгт орчинг нь амжилттай хөгжүүлж буй Канад, АНУ, Австрали, Англи гэсэн оронд компанийн санаачилгаар дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдэд ЭМНҮ хийгддэг байна. Бага ба дунд орлоготой орнуудын хувьд Тайланд, Хятад, Өмнөд Солонгосоос өөрөөр ЭМНҮ-г нэвтрүүлсэн орны талаар баримт, нотолгоо хомс байна.

## Монголын уул уурхайн салбарт яагаад хэрэгтэй вэ?

Монгол оронд давалгаалан нэмэгдэж байгаа олборлох салбарын үйл ажиллагаа түүнийг дагасан хүрээлэн буй орчны болон нийгмийн олон арван сөрөг үр дагаварууд хувь хүн, олон нийтийн эрүүл мэндэд өмнө дурдсан ЭМТХЗ-ээр дамжин шууд ба шууд бусаар эрсдэл үүсгэх болсон талаар нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагууд өргөнөөр ярьж бичих болсон хэдий ч нотолгоо хомс байсаар байна. Дэлхий нийтийн практикаас харвал энэхүү эрсдэлийг цаг алдалгүй эрт үед нь зөв тогтоож төлөвлөн хяналтад оруулахгүй бол наанадаж хүрээлэн буй орчин сүйтгэгдэх, түр зуурын эдийн засгийн өсөлт сөрөг тал руу эргэх улмаар хөгжлийн гол хөдөлгөгч хүч болох хүний эрүүл мэндийг доройтуулсанаар улс үндэстний язгуур эрх ашигт ноцтойгоор нөлөөлдөг байна. Тиймээс Монгол орны нөхцөлд дэд бүтцийн буюу эдийн засгийн хөгжлийн чиг баримжаатай төслүүд нэн ялангуяа уул уурхайн төслүүд орчны болон хүний эрүүл мэндэд ямар замаар, ямар далайцтайгаар хэрхэн нөлөөлөх магадлалтайг судлан тогтоох, сөрөг нөлөөллүүдийг бууруулах эрүүл мэндийн үйл ажиллагааны төсөвт төлөвлөгөөг гарган хэрэгжүүлдэг тогтолцоог бүрдүүлэх хойшлуулашгүй, нийгмийн шаардлага үүсч бий болоод байна. Уг

нөлөөллийг судлахад ЭМТХЗ-үүд тэр дотроос хүрээлэн буй орчны болон нийгмийн хүчин зүйлүүдийг чухалчлан авч үздэг. Монгол орны хувьд үндэсний ЭМНҮ-ний чадавх, дэмжлэгт орчинг бий болгох, хууль эрхзүйн орчинг цаг үеийн шаардлагатай уялдуулан сайжруулах, уул уурхайн компаниудад ЭМНҮ-ний олон талын ач холбогдолыг сурталчлан таниулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал уул уурхайн компанид төслийн үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө уг үнэлгээг мэргэжлийн байгууллагаар захиалан хийлгүүлэх үүрэг хариуцлагыг хуулийн дагуу хүлээлгэдэг болох ёстой. Засгийн газар хуулийн дагуу аливаа компаниас ЭМНҮ хийлгэх болон түүнтэй уялдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага тавих нь орон нутгийн ард иргэдийг төсөлтэй холбоотой аливаа сөрөг үр дагавраас сэргийлж, ашиг тусыг нь адил хэмжээнд хүртэхэд сайнаар нөлөөлнө. Түүнчлэн сайн хийгдэж, зөв хэрэгжсэн тохиолдолд ЭМНҮ нь компаниудын хувьд бизнесийн үйл ажиллагааг нь сайжруулах, нэр хүндийг нь өсгөх гэсэн үндсэн хоёр ач холбогдолтой. Үнэлгээ хийлгэхгүй явж байгаад эрүүл мэндийн ноцтой асуудал илэрсэн тохиолдолд бизнесийн үйл ажиллагаанд нь шууд нөлөөлөх, улмаар зогсоход ч хүргэнэ. Тухайлбал, хүн ам огцом нэмэгдсэнтэй холбоотойгоор ус агаараар тархан халдварласан халдварт өвчин нь орон нутгийн хүн ам, уурхайн ажилчдад ч халдварлах аюултай. Энэ нь уул уурхайн компанийн ажилчдын ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж, ажил таслалт нэмэгдэхээс гадна орон нутгийн эрүүл мэндийн зардалд үүссэн нэмэлт дарамтыг тус компани хариуцах гэх мэтийн үр дагаварт хүргэнэ. Орчны нөлөөллийн үнэлгээтэй хавсарсан ЭМНҮ-г Монголд нэвтрүүлэх, мэргэжилтнүүдийн чадавхыг бий болгох замаар уул уурхайгаас учирч болох сөрөг үр дагаврыг эртнээс нягтлан үзэх нь наанадаж компанийн нэр хүнд, бизнесийн үйл ажиллагаа, бүтээмжид цаашилбал байгаль орчин болон хүний эрүүл мэндэд ээлтэй

эдийн засгийн өсөлт бий болгосноор Монгол орны хөгжилд сайнаар нөлөөлнө.

## Хэзээ явуулах вэ?

Аливаа төсөл, хөтөлбөр эхлэхээс өмнө төслийн үйл ажиллагааны бүх шатанд нөлөөллийн хүрээний хүн ам, тэр дундаа өртөмхий бүлгийн хүн амын эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг ЭМНҮ-гээр системтэйгээр үнэлэн тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг санал болгодог байх хэрэгтэй байна. ЭМНҮ-гээр сөрөг нөлөөллийг тодорхойлохоос гадна тухайн төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр гарах цаашид өргөжүүлж, үргэлжлүүлэх боломжтой эерэг нөлөөллийг мөн тодорхойлно. Томоохон төслүүдийн хувьд хөрөнгө оруулагч олон улсын байгууллагын зүгээс тавьсан шалгуурт нийцүүлэх үүднээс ЭМНҮ-г хийх нь ч бий. Энэ тохиолдолд үнэлгээ сонгодог утга болох эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг бодитойгоор бууруулах зорилгоо алдах талтай. Хөгжиж буй орнуудын хувьд энэ төрлийн үнэлгээний хэрэглээ хангалтгүй байгаа нь тэдний нөхцөлд ЭМНҮ-ний эрх зүйн орчин болон чадавх бүрдээгүйтэй холбоотой байж болох юм. Манай орны хувьд сүүлийн гурван жил орчмын хугацаанд ЭМНҮ-ний талаарх оролцогч талуудын ерөнхий ойлголтын түвшинг нэмэгдүүлэх, гүйцэтгэх мэргэжилтнүүдийн чадавхыг бий болгох, сайжруулах, хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлүүдээр багагүй ажлууд хийгдээд байгаа ч ЭМНҮ-ний тогтолцоог бий болгоход хамгийн чухал зүйл болох төрийн ба хувийн хэвшлийн дэмжлэг үгүйлэгдсэн хэвээр, уул уурхайн салбарын хурдыг гүйцэхгүй байна. Уул уурхайгаас гадна барилга, зам тээвэр гээд дэд бүтэц, хөгжлийн томоохон хэмжээний төсөл, хөтөлбөр, бодлого бүрт дээрх үнэлгээг хийдэг болох нь зүйтэй.

## Хэн явуулах вэ?

ЭМНҮ-г амжилттай хэрэгжүүлэх ►

эсэх нь сайн бэлтгэгдэж мэргэшсэн боловсон хүчнээс ихээхэн хамааралтай учир энэ чиглэлийн мэргэжилтнүүдийг хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу сургаж, тусгай шалгуураар шалгаж, итгэмжлэл олгодог механизм байдаг. Чадавхыг үнэлэх механизм нь улс бүрт өөр боловч олон улсын стандартад нийцсэн түвшинд үнэлгээг хийлгэхийн тулд ихэнх тохиолдолд БИЕ ДААСАН хөндлөнгийн байгууллагаар хянуулахыг чухалчилдаг. Ингээгүй тохиолдолд чанарын шаардлага хангаагүй үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд дахин хийх асуудал тулгардаг. Тийм учраас ЭМНУ хийдэг байгууллагуудын хувьд мэргэжилтэн, боловсон хүчнээ чадваржуулах сонирхолтой байдаг. Тус үнэлгээний чанарт нөлөөлдөг зургаан үндсэн хүчин зүйл байдаг. Үүнд: сургалтыг чанартай явуулах, салбар хоорондын нягт харилцаа, хамтын ажиллагаа, оролцогч талуудыг бүрэн хамруулах, шинжлэх ухаанч, уян хатан хандлага, үнэлгээ хийгчид эрүүл мэндийг агуулгын хувьд цогцоор нь авч үзэж буй эсэх, эерэг, сөрөг нөлөөллийг хамтад нь тооцох зэрэг багтана. Монголд ЭМНУ хийх мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэж, чадавхыг нь сайжруулах үйл явц нь тодорхой цаг хугацаа шаардах асуудал боловч Засгийн газар, эрдэмтэн судлаачид болон олон улсын байгууллагын анхаарал, хүчин чармайлтыг хандуулж чадвал харьцангуй хурдан хугацаанд хийж гүйцэтгэх боломжтой юм. Төрийн зүгээс компаниудад олборлолт явуулах лиценз олгохдоо ЭМНУ-г заавал хараат бус, мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн байхыг шаарддаг хууль, эрх зүйн орчинтой болох хэтийн төлөв харагдаж байна.

## Монголын нөхцөлд уул уурхайн компаниудыг явал ЭМНУ-г хийлгэдэг болгох вэ?

Зарим компани бизнесийн үйл ажиллагаагаа эрсдэлгүй, тогтвортой байлгах үүднээс, нэг хэсэг нь компанийн нийгмийн хариуцлагаа

ухамсарласны үндсэн дээр санаачилгаараа ЭМНУ-гээг хийлгэх магадлалтай бол бусад нь үүнийг нэмэлт дарамт, шаардлагагүй зүйл мэтээр хүлээж авахыг үгүйсгэхгүй. Өмнө дурдсанчлан ЭМНУ шинэ тулгар байгаа энэ үед тодорхой хэмжээний албадлага хэрэгтэй гэж боддог. Үүний тулд зайлшгүй хууль, журмаар зохицуулах шаардлагатай. Томоохон хэмжээний төслүүд лицензээ авахдаа ЭМНУ-г заавал хийлгэсэн байна гэдэг шаардлагыг тавих ёстой. Жишээ нь: Оюутолгойн тогтвортой байдлын гэрээг 2009 оны аравдугаар сард үзэглэхэд Эрүүл мэндийн сайд оролцож Сангийн, Эрдэс баялаг, уул уурхай, Байгаль орчны сайд нартай хамт гэрээнд гарын үсэг зуралцах ёстой байсан. Тодруулж хэлбэл “Оюутолгой компани нь төслийнхөө үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд учирч болох эерэг, сөрөг нөлөөллүүдийг тооцож, бууруулах төлөвлөгөөг боловсруулсан болохыг салбарын яам нь баталгаажууллаа” гэсэн үг. Энэ нь нэг талаас тухайн компани олборлолт явуулах “нийгмийн лиценз”-ээ авлаа гэж ойлгож болно. Дээрх гэрээгээр баталгаажих “Нөлөөллийг бууруулах эрүүл мэндийн төлөвлөгөө”-нд талуудын хариуцах ажил тус бүрийг ийнхүү зааглан тусгаснаар цаашид эрүүл мэндийн ямарваа хүндрэл, асуудал үүслээ ч гэсэн үл ойлголцолгүйгээр зохицуулж байх ач холбогдолтой. Талуудын үүрэг хариуцлага, санхүүжилт, үйл ажиллагаа болон хяналт бүхэн зөвхөн урьдчилан тохиролцсон гэрээгээр зохицуулагдаж байх ёстой. Эрүүл мэндийн асуудлаар маргаан үүссэн тохиолдолд шийдлээ гэрээнээсээ л олчихно гэсэн үг. Ингээд бодохоор ЭМНУ-ний талаар зөвхөн эрүүл мэндийн салбарынхан гэлтгүй бусад салбарын асуудал хариуцсан хүмүүс нь өөр өөрийн түвшиндээ мэдлэгтэй байх шаардлагатай болж байна. Энэ мэдлэгийг бий болгосон цагт тавьж байгаа энэ асуудал Монголын хөрсөн дээр бууж “нутагшлаа” гэж үзэж таарна. Төсөл эхлэхээс өмнө тухайн орон нутгийн хүн амын эрүүл мэнд ямар түвшинд байв гэдгийг мөн тогтоох нь компанийн хувьд ач

холбогдолтой. Ингэснээр тухайн төсөлтэй холбоогүй ямар нэгэн суурь өвчлөл, эмгэг өмнө нь байсан эсэхийг тогтоож, үгүй тохиолдолд хүн амын эрүүл мэндийн суурь үзүүлэлт, мэдээллийн баазаа бий болгож авна. Явцын дунд эдгээр үзүүлэлтүүдийг тоон болон чанарын аргуудаар давтан үнэлэх замаар хяналтыг тавьж тархвар зүйн аргаар эрүүл мэндийн эрсдэл, эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлс болон өвчлөлийн хоорондын уялдаа хамаарал, түүний нөлөөлж буй хэмжээг тогтоох боломжтойгоороо ЭМНУ шинэлэг бөгөөд давуу юм. Зарим тохиолдолд төслийг хэрэгжүүлэгч хамтрагч талууд болох компани, тэр бүү хэл Засгийн газрын зүгээс үнэлгээний үр дүнг эсэргүүцэх, үр дүнд нөлөөлөхөөр оролдох нь ч бий. Өвчин эмгэгүүд ихэнхдээ олон төрлийн хавсарсан шалтгаануудаар үүсгэгддэг болохоор заримдаа үнэлгээний үр дүн эргэлзээ төрүүлж болох ч ЭМНУ нь тухайн нэг нөхцөлдүүлэгч буюу эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйл болон өвчлөлийн хоорондын үүсэх механизмыг шууд ба дам байдлаар нотолж чаддагаараа давуу талтай. Өөрөөр хэлбэл, ЭМНУ-г хэрэглэж дадсанаар бид хонгорчууд, улаанбадрахчуудын эргэлзээг тайлах боломжтой болно гэсэн үг.

ЭМНУ явуулахын туйлын зорилго нь эрсдэлийг үнэлэн тогтоогоод орхих биш тэдгээр эрсдэлийг бууруулах ба эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд байдаг. Энэхүү “мэдээлэлжсэн шийдвэр гаргах аргачлал”-ыг бид Монголд нутагшуулж, олборлох салбарын менежментэд нэвтрүүлж чадвал, хожим учрах эрүүл мэндийн эрсдэлүүдийг тойрч Монголдоо эдийн засаг, эрүүл мэнд хоёрыг хосоор нь хөгжүүлэх ховор боломж бүрдэнэ. Байхгүй зүйлээ бэдрэх явцдаа өөрсдөдөө байгаа хамгийн үнэт капитал болсон эрүүл мэндээ тавиад туучихгүй байх нь хөгжлийн төслүүдийн өнөөгийн чухал зорилт байх учиртай. Эдийн засгийн хөгжил заавал иргэдийнхээ эрүүл мэндийг золиослон байж ирэх учиртай гэжүү? ■

**CONSTRUCTION MONGOLIA 2013**  
18-20 OCT  
INTERNATIONAL CONFERENCE & EXPO

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



БАРИЛГЫН  
ХӨГЖЛИЙН ТӨВ

ХАМТРАН ЗОХИОН  
БАЙГУУЛАГЧ:

GLOBAL GROUP

ГЛОБАЛ ГРУПП ХХК

# CONSTRUCTION MONGOLIA-2013

## ОЛОН УЛСЫН ХУРАЛ, ҮЗЭСГЭЛЭН

2013 ОНЫ 10 ДУГААР САРЫН 18-20

**ХУРАЛ**

2013 ОНЫ 10 САРЫН  
18,19-НЫ ӨДРҮҮДЭД ТӨРИЙН  
ОРДОНД БОЛНО.

**ҮЗЭСГЭЛЭН**

2013 ОНЫ 10 САРЫН  
18-20-НЫ ӨДРҮҮДЭД «БУЯАНТ-  
УХАА» СПОРТ ЦОГЦОЛБОРТ  
БОЛНО.

☎ 976 - 9967-6359    📞 976 - 11 - 320338  
✉ [info@constructionmongolia.mn](mailto:info@constructionmongolia.mn)  
🌐 [www.constructionmongolia.mn](http://www.constructionmongolia.mn)

PLATINUM  
SPONSOR



MORIN KHUUR  
TOWER LLC



BEREN  
GROUP LLC



UNDP



ODCON  
HOLDING LLC



BAGANAT  
URGOO GROUP  
LLC



NISHIN ILCH  
LLC



SDEVELOPMENT  
LLC



TIAN SAN  
CONSTRUCTION  
LLC

GOLD  
SPONSOR

SILVER  
SPONSOR

# MONGOLIAN MINING SUMMIT

Exploring Mongolia's Minerals Future and Development

Main Conference: 30 - 31 October 2013 • Workshops: 29 October 2013  
Venue: Crown Perth, Australia



## Expert Speaker Panel Includes:



**Otgochuluu Chuluuntsereen**  
Mining Ministry, Director General, Department of Strategic Policy and Planning  
**MINISTRY OF MINING**



**Graeme Hancock**  
President and Chief Representative  
**ANGLO AMERICAN MONGOLIA**



**Dr. Battseengel Gotov**  
Executive Director and CEO  
**MONGOLIAN MINING CORPORATION (MMC)**



**Jim Dwyer**  
Executive Director  
**BUSINESS COUNCIL OF MONGOLIA**



**Alгаа Namgar**  
Executive Director  
**MONGOLIAN NATIONAL MINING ASSOCIATION**



**David Landers**  
General Manager International Operations, East Asian Growth Markets  
**AUSTRADE**



**David Paull**  
Managing Director  
**ASPIRE MINING**



**Julien Lawrence**  
Chief Operating Officer  
**TERRA ENERGY LLC**

Make the most of your Attendance and Networking Opportunities and Attend the Interactive Workshop Sessions:

### Workshop A:

Assessing and Advancing Early Tenement Exploration in Mongolia

### Workshop B:

Infrastructure Projects and Attracting Infrastructure Investments in a Challenging Market

## VIP WELCOME EVENING

**Tuesday, 29 October 2013**  
**18:00 – 20:00**

The VIP Welcome Evening will bring together key speakers and stakeholders to collaborate and discuss key challenges and opportunities of entering the Mongolian mining market, prior to the start of the Summit. This evening will include a discussion round as well as networking drinks and canapés.

*\*This is an invitation only event*

Associate Partner:



Event Partner:



Spotlight Partners:



Exhibitors:




Networking Partner:



Supported By:



Media Partners:



Researched and Developed by:



**BOOK NOW!**

T: +61 2 9229 1000 F: +61 2 9223 2622

E: [registration@iqpc.com.au](mailto:registration@iqpc.com.au) W: [www.mongolian-mining-summit.com](http://www.mongolian-mining-summit.com)